

**Монголын төрийн удирдлагад нөлөөлөх олон түмний  
намын мөн чанар**

**Ц.Батболд**

Улс төрийн ухааны доктор  
(МУИС, Улс төр судлалын тэнхим)

Улс төрийн системийн бүтцийн өөрчлөлт нь систем дэх хамгийн гол үүрэг гүйцэтгэгч элементийн бүтэц-функционалийг өөрчлөхөөс эхэлдэг. Учир нь системд гол үүрэг гүйцэтгэж буй элементийн гажуудлаас системийн тэнцвэр алдагддаг. Энэ нөхцөлд бүтцийн өөрчлөлт нь тухайн элемент болон системийн зохион байгуулалтын хэлбэр, шинж чанарыг өөрчилсөнөөр системийн агуулга аажим өөрчлөгддөг. Харин агуулга нь хэлбэрээ өөрчлөнө гэдэг бол, гэнэт төрөл арилжсан мэт өмнөх үнэт зүйлсээ үгүйсгэн устгадаг марксист философи буюу хувьсгал юм. Системийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ өмнөх системийн тэнцвэр алдагдахад гол үүрэг гүйцэтгэсэн элементийг өөрчлөхөөс эхэлдэг бөгөөд эс тэгвэл системийн өөрчлөлтийн агуулга нь хэлбэртэйгээ зөрчилдөнө. Энэхүү хэлбэр, агуулгын зөрчил нь Монголын нийгэм, улс төрийн системийг бүхэлд нь хамарч, нийгмийн харилцааг эрүүл бус авлигын тогтолцоо руу чиглүүлсэн нь улс төрийн систем дэх тогтолцооны гажгийг илэрхийлж буй аж. Т.Парсонсын тодорхойлсон “латентны үүрэг гэдэг нь системийн хэвийн байдлыг хангах буюу системийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг хадгалахад чиглэсэн үйл ажиллагаа”<sup>1</sup> юм. Нийгмийн шинэчлэл буюу системийн бүтцийн өөрчлөлт нь тодорхой хэмжээнд өөрийн уламжлалт, үнэт зүйлсийг хадгалсаар байдаг бөгөөд энэ шинж чанараараа нийгмийн шинэчлэл болгон адилхан байдаггүй. Тийм ч учраас нийгмийн системийн өөрчлөлт нь уламжлалыг хадгалсан улс төрийн системийг бүрдүүлдэг онцлогтой. Гэвч уламжлалт үнэт зүйлсээс нийгмийн хөгжилд саад болж буй хүчин зүйл, түүний хэм хэмжээг өөрчлөх явдал улс төрийн системийн өөрчлөлтийн үндсэн зорилго байдаг. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд улс төрийн систем нь шинэ нөхцлийг бүрдүүлэх, түүнд дасан зохицох шаардлагатай тулгардаг. Улс төрийн системийн тэнцвэрийг алдагдуулахад нөлөөлөн ноёрхож байсан уламжлалт элементүүдийн тогтолцоо, түүний үнэт зүйлс, хэм хэмжээг өөрчлөх нь системийн бүтцийн өөрчлөлтийн үндсэн зорилго бөгөөд улс төрийн систем энэ үүргээ биелүүлэхгүй бол, шинэ, хуучин үнэт зүйлсийн зөрчилд ордог. Энэ зөрчил нь улс төрийн системийн зорилгыг гажуудуулж, түүний тогтолцоог өөрчилснөөр, нийгмийн амьдралын эдийн засаг, оюун санааны хүрээнд хямралын голомт үүсгэдэг онцлогтой. Нийгмийн системийн өөрчлөлт нь нийгмийн нийтлэг эрх ашигт нийцсэн уламжлалт үнэт зүйлс, хэм хэмжээг хадгалдаг бөгөөд харин системийн шинэчлэлтийн зорилгод нийцэхгүй үнэт зүйлс, хэм хэмжээг өөрчлөхийг шаарддаг нь нийгмийн хувьслын хууль юм. Нийгмийн системийн өөрчлөлт нь улс төрийн системд нийгмийн хөгжлийн шинэ зорилгыг тодорхойлох үүргийг оногдуулдаг. Улс төрийн систем нь уг зорилгыг гүйцэтгэхийн тулд нийгмийн гадаад, дотоод орчны өөрчлөгдөж буй үнэт зүйлс, тэдгээрт нөлөөлөгч хүчин зүйлсэд тулгуурласан шинэлэг үзэл санаа, түүнд нийцсэн засаглалын тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, улс төрийн систем нь нийгмийн гадаад, дотоод хүчин зүйлийн захиалгаар системийн зорилгыг шинээр тодорхойлсон бол, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ёстой. Улс төрийн системийн тогтолцоо нийгмийн харилцааны хэм хэмжээний эрх зүйн актуудаар гарах бөгөөд энэ акт нь нийгмийн зорилго түүний үнэт зүйлстэй нийцсэнээр системийн тэнцвэр хангагдана. Зорилго түүнийг хэрэгжүүлэх процесс нь системийн

<sup>1</sup> N. Áàçàðᠲᠢᠵᠠ. 2006. Өөñ д°ð᠑᠙᠙᠒ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ. ÓÁ., ᠶᠡᠨᠡᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

тэнцвэрийг хадгалах “төрийн хяналтын төв”<sup>2</sup>-өөр шүүлгэж, элементүүдийн харилцааг тогтоодог. Улс төрийн системийн зүгээс тогтоосон дэг журам нийгмийн оюун санааны хүрээнд нийцээгүй нөхцөлд түүнийг өөрчлөх плюраль үзэл санааны альтернатив бий болно. Харин нийцэж байвал нийгэм хөгжин дэвшиж, энэ хөгжилтэй хамт шинэ, шинэ асуудлууд гарч ирэн түүнийг шийдвэрлэх плюрализмын альтернатив хувилбарууд дахин бий болдог онцлогтой. Нээлттэй улс төрийн системд нийгмийн системийн зорилго плюрализмын үр дүн болох прагматизм дээр тогтодог бол, зорилгыг хэрэгжүүлэгч бүтэц, үүргийн тогтолцоо рациональ оюун ухаанд үндэслэдэг. Системийн эргэх холбоо буюу түүний тэнцвэрээ сэргээх чадвар нь байгалийн дасан зохицох процесс буюу нээлттэй системийн хууль юм. Системийн бүтцийн өөрчлөлт нь системийн элементүүдийн уялдаа холбоо (коммунизаци)-ны алдагдсан тэнцвэрийг шинэ орчин нөхцөлд сэргээхэд чиглэгддэг.

1990 оноос Монголд өрнөсөн нийгмийн системийн бүтцийн өөрчлөлт нь улс төрийн системд засаглалыг ардчилах, эдийн засгийн дасан зохицох явцыг зах зээлд шилжүүлэх, эдгээрт нийцсэн эрх зүйн институц, хэм хэмжээний өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх, шинэчлэгдсэн хэм хэмжээний хүрээнд бий болох улс төрийн соёл, нийгмийн оюун санааны үнэт зүйлсийн өөрчлөлт зэрэг бүхий л хүрээг хамарсан. Монголын нийгмийн системд бүтцийн өөрчлөлт явагдсаны улмаас улс төрийн системд трансформаци хийгдэх болсон нь улс төрийн системд гол үүрэг гүйцэтгэж байсан элемент болох уламжлалт нэг намын тогтолцоог өөрчлөөд зогсохгүй, намын бүтэц зохион байгуулалтыг шинэ нөхцөлд, системийн зорилгод нийцүүлэн өөрчлөх шаардлага тулгарсан юм. Гэвч 1990 онд улс төрийн системд ноёрхож байсан уламжлалт нэг нам нь олон намын системийг хүлээн зөвшөөрч буулт хийсэнээр бүтцийн өөрчлөлтийг тайван замаар хангах нөхцлийг бүрдүүлсэн боловч, өөрийн намын улс төрийн системд эзлэх байр суурь, дотоод бүтэц, зохион байгуулалтын уламжлалт номенклатур механизмаа хадгалж үлдэснээр улс төрийн систем төдийгүй, бүхэл нийгмийн системийн өөрчлөлтөнд сөргөөр нөлөөлөх болсон ажээ. Тэгэхээр энэ зорилгыг хэрэгжүүлэгч улс төрийн системийн зорилго тодорхойгүй, түүний үзэл бодол нийгмийн төвшинд бүрдээгүй нөхцөлд нийгмийн үнэт зүйлсийн өөрчлөлт радикаль болон прагматик хандлагад тулгуурлах бөгөөд нийгмийн хямрал үргэлжилсээр байх болно. Ийм нөхцөлд элитийн болон плюраль ардчиллын сул тал болох нийгмээс тасарсан хүчирхэг сонирхлын бүлгийн хамгийн том хэлбэр болох хоёр намын ээлжилсэн ардчиллын хэлбэрдэлт бий болдог аж. Үүний мөн чанар нь олонхийн нэрээр ардчилсан маягийн хэлбэрдсэн (формал ардчилал) олигархийн дарангуйлалыг агуулдаг. Үүнийг зарим судлаачид Америк, Европын ардчилал хөгжсөн орнуудаар жишээ татан эсэргүүцэж болох юм. Гэвч эдгээр орнууд нь: **Нэгд**, тодорхой хэмжээнд хөгжсөн ардчиллын давуу тал болох хувь хүний авьяас чадвар, потенциалийг түлхүү ашиглах боломжийг алхам бүрдээ нэмэгдүүлсээр байдаг оршдог. **Хоёрт**, аж үйлдвэржилт, техник, технологийн хөгжлийн давуу байдлаа ашиглан гуравдагч ертөнцийг мөлжих замаар өөрийн түр тэнцвэрээ хадгалж байдаг. **Гуравт**, тэдгээр улсуудын нийгэм, улс төр, эдийн засгийн болон социаль салбар дахь тогтвортой байдал нь нийгмийн байнгын хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэх процессыг улс төрийн зорилгод бус, эдийн засгийн дасан зохицох үйл явцад суурьлан, прагматик шийдвэрлэх боломжийг олгодог. **Дөрөвт**, эдгээр нөхцлүүд нь ихэвчлэн консерватив болон либерал байр суурьт тулгуурласнаар нийгмийн хөгжлөө жам ёсны шинжтэй мэт харагдуулдаг.

<sup>2</sup> Өдө  $\zeta$  ннүй оаааанаа  $\Gamma^{\circ\circ}$ а  $\delta$   $\delta$ оуе аааааа  $\text{Id}=\text{eifam}$  оён  $\zeta$   $\text{iaynidiee}$   $\text{donaaad}$   $\text{diaoinie}$ ,  $\zeta$   $\text{iayniee}$   $\text{ydo}$   $\text{a}$ оёа,  $\text{apoea}$   $\zeta$   $\text{e}$   $\text{aaeaeui}$   $\text{aaadaeaa}$   $\text{aiea}$   $\text{edny}$   $\text{aie}$ ,  $\text{ainnaam}$   $\text{ieeiee}$   $\text{iyaaue}$   $\text{iyadadeui}$   $\text{ayeyu}$   $\text{oyiaya}$   $\text{aiea}$ ,  $\text{ieeiee}$   $\text{daedeeoaaa}$   $\text{ciedeooea}$   $\text{aa}$  “ $\text{ieeiee}$   $\text{a}$   $\text{ydyu}$ ”-а  $\text{n}$ -ei  $\text{naeoeaa}$   $\text{aeaaaeaaa}$   $\text{oyduaeuo}$   $\text{eaaedei}$   $\text{ydooye}$   $\text{oidui}$   $\text{aafu}$   $\text{eindeodo}$   $\text{aieei}$   $\text{idoei}$   $\text{diaoinie}$   $\text{edny}$ .  $\text{Yiy}$   $\zeta$   $\text{daeei}$   $\delta$   $\zeta$   $\text{dyuia}$   $\text{d}$ о,  $\text{caodeaaaui}$   $\text{aaeaooeeaaoba}$   $\text{ieeiee}$   $\text{aindinn}$   $\text{aad}$ -  $\text{edyo}$   $\text{yia}$   $\delta$  -  $\text{aeuidadadea}$   $\zeta$   $\text{ye}$   $\text{aaddeideae}$ ,  $\text{oen}$   $\text{d}$ о  $\text{deei}$   $\text{aiaefana}$   $\zeta$   $\text{iauy}$   $\text{cad}$ - $\text{iaa}$   $\text{aadeideai}$   $\text{d}$ о  $\text{aeae}$   $\text{naoenai}$   $\text{aaed}$   $\text{noobuana}$   $\text{aiaiaa}$ ,  $\text{iydayeedyi}$   $\text{iaiaaadeei}$   $\zeta$   $\text{daee}$   $\text{a}$   $\zeta$   $\text{eoyoda}$   $\text{yo}$   $\text{noie}$ .

Уламжлалт нэг нам шинэчлэгдсэн плюрализмын нөхцөлд зохицохдоо нам төвтэй төрийн уламжлалт консерватив үнэт зүйлс, төр, нийгэмд эзлэх байр сууриа хадгалж үлдэх зорилгыг агуулах болсон. Хэрэв системд гадна, дотноос нь шахалт үзүүлж тэрээр алдагдсан тэнцвэрээ сэргээх чадваргүй болоход системд бүтцийн өөрчлөлт явагддаг. Системд бүтцийн өөрчлөлт оруулах энэ шаардлагыг үзэл суртал хэмээх шинжлэх ухааны бус хандлага тодорхойлдог бөгөөд үүнийг улс төрийн системийн нэг чухал институц болох нам удирдан чиглүүлдэг. “Улс төрийн нам гэдэг нь үндэсний нийтлэг язгуур ашиг сонирхлын хүрээнд улс төрийн тодорхой үзэл баримтлалыг тойрч нэгдсэн, ашиг сонирхлоороо буюу нэгдмэл хүмүүсийн нийт улс орны хийгээд төрийн засаглалын бүтцийн төвшинд зохион байгуулагдсан, засаглалыг ардчилсан арга замаар авч, хэрэгжүүлэх зорилго бүхий улс төрийн байгууллагын институтжсэн өвөрмөц хэлбэр мөн”<sup>3</sup>. Үүний үр дүнд тэрхүү нам, болон хэсэг бүлэг хүмүүс чөлөөт сонгуулиар, эсвэл хуйвалдаан болон хүчирхийллийн замаар улс төрийн системийн цөм болох төрийн эрхийг авч зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө тэмцдэг.

Монгол дахь нэг намын систем нь нийгмийн бүхий л (улс төр, эдийн засаг, оюун санааны болон социаль) хүрээг хянасан, засаг захиргаа, байгууллагуудын салаа мөчир бүрд өөрийн анхан шатны нэгжтэй, олон шат дамжлага бүхий нүсэр том хүнд суртлын тогтолцооны салшгүй нэг хэсэг болон оршиж байв. Нам улс орон дахь төрийн байгууллагуудыг удирдахдаа номенклатур арга хэрэгслийг ашиглаж байсан. Үүнийг Альмонд, Пауэлл, Дальтон нар “системийн нөхцөлд намын байгууллага чухал албан тушаалын томилгоог шууд хянаж, намын удирдах хүмүүс шалгаруулалтад шийдвэрлэх үгийг хэлдэг. Түүнээс гадна нам сонгож авсан албан тушаалтнуудынхаа зан байдлыг хянахын тулд олон янзын арга ашиглаж байв. Эдгээр аргууд нь хамгийн дээд зиндааны удирдагчидынхаас бусад бүгдийн үйл ажиллагааны эрх чөлөөг хааж боогдуулж байсан юм”<sup>4</sup> гэж тодорхойлсон аж. Монголд оршиж байсан нэг намын тогтолцооны мөн чанар нь нэг хүний болон нэг хэсэг элитүүдийн эрх дархыг хадгалан өргөжүүлэхэд чиглэгдсэн байв. Учир нь, нам өөрийн үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэх, улс төрийн элитийн эрх ямбыг хадгалахдаа нэг үзэл сурталд үндэслэсэн нам, төрийг байгуулж ашигладаг бөгөөд үүний үр дүнд нам төвтэй төр оршиж байлаа. Х.Гүндсамбуу “нийгмийг удирдан чиглүүлэгч хүч” болсон нэг намын бүтэц, зохион байгуулалтыг дагалдсан засаглалын угсраа бөгөөд зэрэгцээ бүтэц бүрэлдсэн явдал номенклатурчдад үлэмжхэн эрх мэдэл олгож, дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэх бололцоо олгосон юм. Аливаа арга хэмжээ намын аппаратын зөвшөөрөл, оролцоотойгоор явагдаж байв”<sup>5</sup> гэжээ. М.Спанн “ардчилсан бус оронд улс төрийн нам нь дарангуйлагчийн эрх мэдлээ хадгалан өргөтгөхөд нь зориулагдсан хэрэглүүр болж хувирдаг”<sup>6</sup> хэмээн тодорхойлсон байдаг. Энэ тохиолдолд ганц улс төрийн нам л оршин тогтнож, байнгын чөлөөт сонгууль явуулах хэрэгцээг байхгүй болгодог бөгөөд учир нь улс төрийн сөрөг хүчнийг хориглодог учир сонгууль явуулах асуудал нь өөрөө утгагүй болно. Гэвч “нэг намын системийн хувьд заримдаа сонгууль явуулж байх нь ашигтай гэж үздэг. Сонгуульд нэр дэвшигчид ялагдана гэж үгүй учраас сонгууль нь ядаж дэглэмийн легитим шинжийг бага ч атугай өргөж өгдөг”<sup>7</sup> ажээ. Мөн төрийн болон нийгэм, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны бүхий л салбарт намын хяналт тогтож, янз бүрийн шатны байгууллагуудын нэг нь ч бие дааж ажиллах боломжгүйгээр харилцан сүлжилдсэн байдаг нь Г.Альмондын үзсэнээр дотоодын хүчний байгууллага, армийн зүгээс эргэлт хийх боломжийг хаах

<sup>3</sup> Ä.Äiteä-Yäyü. Iñäiteüi öen ðödeéi íai, íaiüi ñenðai. ÓÁ., 2000.ö 84.

<sup>4</sup> Ä.Äeuñia. Ä.Íaóyee. Ê.Ñodñ. Ð.Äaeuðí. Óaduóóöenai öen ðöð. ÓÁ., 2005. ö 163.

<sup>5</sup> Ö.Ä;íañaiáóó. Iñäiteäöðð÷ä. /Äíäðie äynäeäae/ ñyðä;ë. 1992., ä 8. ö 7.

<sup>6</sup> Ì.Ñeáí. Öen ðödeéi öäedöäae. Ö;éoyí äaeíü äaðäð öðei ;äeeí çañäeeí ääçðóóä ää ;íäyñdi;ä. Íð÷. Äíä÷ei. ÓÁ., 2005. ö 194.

<sup>7</sup> Ì.Ñeáí. Íñ öyíä. ö 194.

зорилготой байсан гэдэг. Тухайн үед хууль ёсоор оршиж байсан ганц нам болох МАХН-д насанд хүрсэн ихэнх хүн гишүүнээр элсэхийг хүсдэг байсан бөгөөд, учир нь намын гишүүнчлэлийг дагаад баталгаатай сайн амьдрал, улс төрийн элит хэсэгт орох бололцоо бүхий номенклатур хөшүүрэг үйлчилж байсантай холбоотой юм. Мэдээж хэрэг ажлын сайн байр, мэргэжил боловсролоо дээшлүүлэхээр гадаадад явах боломж илүү олддогт үүний учир оршино. Өөрөөр хэлбэл намын гишүүн хүн амьдрах орон гэр, сайн хоол унд, эрүүл мэндийн үйлчилгээ, өндөр боловсрол зэргийг олж авах өргөн боломж, санхүүгийн урамшууллаар хангагдана. Тийм учраас намын гишүүд нэг талаас үнэнч шударга байдлаа харуулахын тулд, нөгөө талаас тодорхой нэг үзэл сурталд итгэснээр өөрийн албан ажилдаа үнэнч зүтгэдэг байв. Энэ нь нам төрийн удирдагчдын үзэл суртал, үнэт зүйлст хандах хэм хэмжээний хөшүүргүүд болж байсан бөгөөд албадлага, тухайлбал, цагдаа, нам, бюрократын хяналтыг ашиглаж байв.

Нэг намын системд сонгуулийн өрсөлдөөн үгүйлэгддэг ч гэсэн, намын дотоод тэмцэл ширүүн бөгөөд бүлэглэлүүд хоорондоо үзэл бодол, байр сууриараа эрх мэдлийн төлөө өрсөлддөг байв. М.Сланны тодорхойлсоноор “нэг намын системд хувь хүний зан чанар их үүрэг гүйцэтгэдэг бөгөөд намын удирдлагын төлөөх өрсөлдөөн нэлээд ширүүн хэлбэрээр явагддаг”<sup>8</sup> гэжээ. Намын дотоод эрх мэдлийн төлөөх тэмцэл нь улс төрийн элитийн эрх ямбыг хадгалахдаа, үзэл сурталын зорилгыг хэрэгжүүлэх төрийг байгуулж ашигладаг хэлбэрээр далдлагддаг. Х.Гүндсамбуу “засгийн эрхийг авах явдал бол номенклатурчдын гол зорилго, язгуурын ашиг сонирхол бөгөөд түүндээ хувьсгалаар бус, харин улаан, цагаан гэсгээл, хэлмэгдүүлгээр хүрдэг”<sup>9</sup> гэж үзжээ. Чухам ийм өрсөлдөөн нь МАХН-д шинэлэг үзэл бодолтой сэхээтнүүдийг элсүүлэх явдлыг хязгаарлах хатуу шалгуурыг тогтоох үндэс болсон. Энэ нь мэдээж марксист үзэл сурталд үнэнч, хамгийн гол нь намын олигархи бүлгийн үзэл бодлыг үг дуугүй хүлээн зөвшөөрдөг, өөрөөр хэлбэл бага бодож их хийдэг “тэргүүний” сэхээтэн, ажилчин, тариаланч, малчид буюу ядуу ард гаралтай хүмүүсийг элсүүлэхэд чиглэгдэж байсан юм. Энэхүү “тэргүүний” гэгч тодотгол нь тавь, жараад оны “сэхээтний төөрөгдөл”, “Дамба, Цэнд, Төмөр-Очирын хэргүүд”, “Лоохууз, Нямбуу, Сурмаажав нарын хэрэг”- ээс үндэслэн тогтсон, нам дахь олигархи бүлгийн дарангуйлагчийн эрх мэдлээ хадгалан өргөтгөхөд нь зориулагдсан хэрэглүүр болж хувирсан шалгуур юм. Дээрх “тэргүүний” хүмүүсийг элсүүлэх шалгуур нь МАХН-ын олигархи удирдлагын байр суурийг бэхжүүлээд зогсохгүй, намын удирдагчдыг тахин шүтэх, зулгуйдах, аялдан дагалдах, тал тохой татах хандлагыг хориод жил хүчтэй бэхжүүлсэн аж. Энэ талаар Х.Гүндсамбуу “Х.Чойбалсан журмын нөхдөө дуулгавартай хүмүүсээр сольсон бол, Ю.Цэдэнбал өөртөө үнэнч хүмүүсийн багийг бүрдүүлсэн. Тэр нь сүүлдээ төрөл ойртож, ураг барилдаж, “цус ойртох” тийшээгээ хандах болсон юм”<sup>10</sup> гэжээ. Энэхүү “тэргүүний” хэмээх лидер дагалдагч хандлагын онцлог Монгол оронд олон намын тогтолцоо бий болсон 1990-ээд оноос хойш ч МАХН дотор арилагүй бөгөөд харин ч “нийтийн сайн сайхны төлөө” гэсэн коммунист үзэл сурталын цензур нь арилж, олигархи хэсэг бүлгийн эрх ашиг, хувийн сонирхолд шууд үйлчилж эхэлсэн нь массын нам түүний дотоод мөн чанар юм.

Нийгэмд томоохон байр суурь эзэлж олон түмнийг хамарсан гишүүнчлэл бүхий нам олон шат дамжлагатай бюрократ зохион байгуулалтаар ажилладаг. Зохион байгуулалтын бюрократ бүтэцтэй намын дотоод зохион байгуулалт нь ардчилгдах явдал амаргүй, бараг боломжгүй бөгөөд олигархи үүсдэг нь нэгэнт нотлогдсон зүйл. Ардчиллаас үүсэлтэй олигархи нь хоёр маш аюултай зүйлтэй тулгардаг. Үүний нэг дэх нь олон нийтийн эсэргүүцэл, бослого бол, нөгөө нь олигархуудын нэг нь дээд эрх мэдлийг авч чадсан тохиолдолд нэг хүний дарангуйлал руу шилжих явдал юм. Энэ хоёр

<sup>8</sup> Iaddēi Nēaii. Ōēi d'ōdēi bāēdōāāē. ÓÁ., 2005. 6.

<sup>9</sup> Ō.Ā; jānāiāóó. I'ēi d'ūiā. 6 8.

<sup>10</sup> Ō.Ā; jānāiāóó. I'ēi d'ūiā. 6 10.

аюулын нэг нь доороос үүсдэг бол, нөгөө нь олигархийн төвөөс гарч ирдэг. Нэг талд бослого эсэргүүцэл, нөгөө талд засгийн эрхийг шудрага бусаар авах буюу узурпаци. Энэ нөхцөлд чин сэтгэлийн харилцан итгэлцэл байдаггүй, харин байнгын далд тэмцэл, лидерүүдийн харилцан хардалтаар тодорхойлогдсон өдөөн хатгалт бүхий энэ байдал ардчилалын үндсэн шинжүүдийн нэг болсон. Лидерүүдийн харилцан үл итгэлцэл, хамгийн түрүүнд өөрийн байгууллагыг захирахыг хүссэн хүмүүсийн эсрэг чиглэгдсэн байдаг. Массын намд “олигархи ба түүний зиндаанд багтах гэж эрмэлзсэн хүмүүс рүү хандсан хардалт сэрдэлтээр нийгэм дүүрэн байдаг бөгөөд тэдгээрийг зөвхөн зайлшгүй ирэх залгамжлагчид биш гэж, мөн байгалийн үхлийг нь хүлээлгүйгээр тэднийг шахан гаргахад бэлэн байдаг” хэмээн Михельс тодорхойлсон байдаг. ( Р.Михельс. “Улс төрийн намууд”.1915)

Энэ нь өнөөгийн МАХН ба АН-ын дотоод дахь бүлэглэлүүдийн эрх мэдлийн төлөөх тэмцэл, зөрчлүүд шинэ зүйл огт биш, харин массын намын мөн чанар, уламжилж ирсэн хуучин арга барил төдий зүйл бөгөөд энэ нь шинээр гарч ирсэн олон түмний намууд ч ийм замаар явж байгааг харуулж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл тавь жараад оны намын дотоод тэмцлийн л нэг хувилбар юм. Р.Михельс “Үнэн хэрэгтээ олон нийт нь удирдагчдыгаа унагааж байгаа юм биш, харин удирдагчид нь бие биенээ олон нийтийн тусламжтайгаар унагадаг” гэдгийг олон жишээ татан тайлбарласан. Уламжлалт нэг нам анхан шатны нэгж байгууллага, гишүүдээрээ дамжуулан төрийн бюрократ аппаратад бүрэн хяналт тавьж байв. Энэ хяналтын үр дүнд төрийн механизм намын үзэл суртлын бодлого, түүний зорилтод бүрэн үйлчилж байсан төдийгүй бюрократуудын карьерын систем намын үзэл суртал, номенклатур механизмтай салшгүй холбоотой санж. Монголд оршиж байсан нэг намын номенклатур ноёрхол дахь бюрократын мөн чанар нь өнөөдөр ч уламжлагдан хадгалагдаж, ардчилсан улс төрийн системд сөрөг үр дагаварыг бий болгосоор байна. Олон түмний хэмээх намын бүтэц, зохион байгуулалт нь олон шат дамжлага бүхий иерархи бүтэц-зохион байгуулалт дээр суурилдаг бюрократ аппарат юм. Бюрократ ёсны үндсэн зарчим нь иерархи шатлал бүхий авторитар аргаар ажилладаг бөгөөд энэ нь олигархиуд болон авторитар удирдагчдыг төрүүлэх уламжлалт нөхцлийг хадгалах үндсэн шалтгаан болдог.

Номенклатур бюрократын мөн чанарын нэг нь нийгэм дэх дотоод зөрчлийн асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам нь зөвхөн нэг үзэл суртлыг баримталсан дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэх явдал байв. Энэ нь нэг талаар гүйцэтгэгчид хариуцлага хүлээхгүй, зөвхөн дээд газрын шийдвэрийг хүлээдэг бөгөөд тэднийг хариуцлага хүлээхээс зайлсхийх үүднээс эрхээ эдлэхээс татгалзах хандлагатай болгодог. Энэхүү засаглах эрхээс татгалзсан уламжлагдаж ирсэн хариуцлагагүй байдлын үр дагавар өнөөгийн Монголын төр, улс төрийн системийн тогтолцоонд хадгалагдаж үлдсэн бөгөөд тухайн асуудалд шийдвэр гаргах үйл явцыг, өөр хөндлөнгийн байгууллага, төлөөлөгчдөөр шийдвэрлүүлэх хэлбэрээр илэрч байгаа нь улс төрийн системийн тогтолцоог гажуудуулах буюу сөрөг тогтоцоо үүсэх нэг үндэс болж байна. Жишээ нь: нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох ИТХ-ын эрх хэмжээ, түүний шийдвэрлэвэл зохих асуудлыг улс төрийн намууд болон төрийн албан хаагчид булаан авч байгаа нь тэндээс гарах шийдвэр хэзээ ч нутгийн иргэдийн эрх ашиг, тэдний амьдрах орчныг хамгаалахгүй нь ойлгомжтой. Ийм маягийн номенклатур эрх ашигт нийцүүлсэн томилгоо, нийгмийн маш олон салбарт хадгалагдаж байгаа нь улс төрийн системийн зорилго, төрийн механизмын үйл ажиллагааг оновчгүй болгож, нийгмийн зөрчлийг улам гүнзгийрүүлэн түүнийг шийдвэрлэх аргагүй байдалд хүргэдэг нь өнөөгийн оршиж буй бодит дутагдлын нэг хэсэг юм. Номенклатурын нэг онцлог бол тухайн системдээ тохирсон, нэг намын оргилд байгаа хувь хүн, олигархи бүлгийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн үнэт зүйлс, үзэл суртлын урамшууллын авторитор механизм юм. Энэ механизмыг ардчилсан улс төрийн системд зөвхөн үзэл суртлын чиг баримжааг

нь өөрчлөн тэр чигээр нь авч хэрэглэх арга хэрэгсэл болгоно гэдэг нь хэлбэр агуулгын зөрчлийг бүрдүүлж, нийгэм болон төр засгийн байгууллагуудад сөрөг тогтолцоо үүсгэх гол эх сурвалж болж байна.

Ардчилсан дэглэмийн үед номенклатур ба “spoils system” нь намыг улс төр, эдийн засгийн ашиг хонжоо олох нэг гол хэрэгсэл болдог. Шинэ нөхцөлд МАХН төдийгүй шинээр үүссэн АН болон бусад олонхи намууд уламжлалт олон түмний намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга барилыг хуулбарлан авсанаар намууд улс төрийг ашиглан хонжоо олох нэг гол хэрэгсэл, нам дагаж амьдрах нь цөөнгүй хүмүүсийн амьжиргааны хэв маяг болон хадгалагдаж байна. Ийнхүү урьдны системд ноёрхож байсан нам төвтэй төрийн гол институц болох, нэг намын системийн дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны мөн чанар, арга механизм өөрчлөгдөлгүй хэвээрээ хадгалагдаж үлдсэнээр олон түмний гишүүнчлэл бүхий номенклатур механизм нь ёс суртахуунгүй “бялуу хүртэгч” сонирхлын бүлэг болон хувирч төрийн аппаратад ноёрхсон намын харъяаллаараа дамжуулан нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх төдийгүй, шинэчлэлийг саармагжуулах том хүч болсон аж.

Монголын төрийн бюрократ механизмд гүн шингэсэн уламжлалт намын номенклатур механизм нь зүсээ хувирган, фаворитизм, неопотизм, давамгайлсан дундад зууны феодалын патримониаль төрийн шинэ хувилбар болох неопатримон хэлбэрт шилжсэн аж. Ф.Хаек “Бага буурай улс түмний хүсэл эрмэлзлэлийг германууд эс тоомсорлон харгис хатуу ханддаг байсныг герман ястаны төрөлхийн нүгэл хилэнцтэйнх гэж үзэх нь буруу. Энэ бол германчуудын өмнөө тавьсан зорилтын зайлшгүй үр дагавар байлаа”<sup>11</sup> гэжээ. Үүний нэгэн адил, ардчилалд шилжсэн монголчуудыг фаворитизм, неопотизм, неопатримон буюу өөрөөр хэлбэл тэднийг “садан төрөл, нутаг ус, танил тал, нэг ангийнхны холбоо”<sup>12</sup>-той явцуу хувийн ашиг сонирхол давамгайлсан менталитеттай хүмүүс гэж ойлгох нь өнөөгийн бодит байдал мэт харагдавч, хувь хүний мөн чанарт хандсан можаритар сонгуулийн систем, олон түмний нам, түүний уламжлалт номенклатур механизмын төрхөө хувиргасан “бялуу хуваах” систем оршин тогтнох зорилгын зайлшгүй үр дагавар юм. Нөгөө талаар шинээр үүссэн ардчиллын төлөөх намууд нь “тодорхой шалтгаан”-ы улмаас уламжлалт олон түмний нам хэмээх бүтэц зохион байгуулалтыг хуулбарлан авсанаар тэнд олигархийн төмөр хууль хэрэгжиж, нийгэм дэх элитийн циркуляцийг зогсоох нэг үндэс болов. Учир нь олон түмний нам нь тоталитар болон авторитар дэглэмд нэг үзэл суртал болон олигархи бүлэглэлийн эрх баригч байр суурийг хадгалах зэвсэг болон ашиглагдаж, ард түмний “тархийг угаан” өөр үзэл бодлыг хязгаарлан, нам ард түмний нэгдлийг хангах үүргийг номенклатур механизмын өрнөдийн хувилбар болох “spoils system” буюу бялуу хуваах механизмаар гүйцэтгэж, энэ их үйлст идэвхи зүтгэл гаргасан иргэдийг төрийн албан тушаалаар урамшуулж, бас албан тушаалыг худалдаж байна. Энэ нь шинэ зүйл биш бөгөөд феодализмын буюу абсолют хаант засаглалын үед гавьяа байгуулсан хүмүүсийг түшмэдийн албан тушаалаар урамшуулж, бас худалдан олгож байсантай ижил. Энэ нөхцөлд түшмэлд цалин өгдөггүй бөгөөд түшмэл албан тушаалаа урвуулан ашиглаж амьдралаа залгуулж байв. Хожим нь түшмэдэд цалин пүнлүү олгох болсон боловч, амьдралд нь хүрэлцэхгүй хэмжээнд зориуд олгож байсан. Учир нь түшмэдийг хаан болон улс төрийн засаглалын эрх баригчдын бодлогыг үг дуугүй хэрэгжүүлэгч болгох үүднээс хууль бус орлогоор нь байнгын дарамтад барьж байх бодлого хэрэгжиж байсан. Энэ нөхцөл Монголд бодит биелэлээ олж, Африкийн улсуудаас дутах юмгүй феодализмын буюу патримониализмын шинэ хувилбар болох неопатримон төрийн хувилбар бий болж эхэлж байна. Мөн нийтийг хамарсан гишүүнчлэл бүхий, ажилчны хөдөлгөөнөөс үүсэлтэй олон түмний нам хэмээх радикаль чиг баримжаатай институц нь

<sup>11</sup> Ô.À.Õààê. Áíñë-ëñããî çàì. ÓÁ., 2004. õ 180.

<sup>12</sup> Д.Ганхуяг. Монголын нийгмийн харилцааны онцлог. [www.openforum.mn](http://www.openforum.mn)

ард түмнийг намын оршин тогтнох байнгын бааз суурь болгохоор улс орны төвшинд анхан шатны нэгжээс эхлүүлэн ирээрхи бүхий бюрократ том бүтцийг ажиллуулдаг. Уламжлалт намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга барилыг шинэ намууд тэр чигт нь уламжлан авсанаар, ардчиллын нөхцөлд улс орны иргэдийг хагалан бутаргаж хуваагдалд оруулан нийгэмд улс төржсөн эрүүл бус уур амьсгалыг бий болгоод зогсохгүй, элитийн циркуляцийг сааруулж, олигархи бүлэглэлийн ноёрхлыг бэхжүүлдэг нь ХХ зууны наяд он хүртэлх дэлхийн формаль ардчиллын түүхийг давтсан хэрэг юм. Орчин үеийн улс төр судлаачид улс төрчдийн хувьд улс төрийн нас хэмээх ойлголтыг бий болгосон байдаг. Үүнд улс төрчдийг дунджаар нэгээс хоёр сонгуулийн хугацаанд төр барих явдлыг хамруулдаг бөгөөд онцгой тохиолдолд М.Тэтчер, Дэн Ся Пин, Ф.Рузвельт зэрэг харизматик лидерүүдэд гурав дахь сонгуулийн хугацаа оногддог аж. Шинээр үүссэн Монголын АН болон бусад шинэ намууд нь олон түмний намын бүтэц-зохион байгуулалт, түүний автократ механизмыг, өрнөдөд адлагдсан (spoils system) гавьяа зүтгэлийг харгалзах буюу “бялуу хуваах” системтэй хамт хуулбарласан нь тэдгээрийн лидерүүд болон гишүүдийн улс төрийн тоглолтыг хувийн неопатримон шинж төрхтэй болгож, нийгэмд абсентизм үүсэх нөхцлийг бүрдүүлжээ. Монголын нийгэмд үүсэж буй абсентизм нь намгүй нийгмийг мөрөөдөх хэлбэрээр илэрч байна. Уг нь улс төрийн шинжлэх ухаанд абсентизмыг ард иргэдийн сонгуульд оролцохгүй байх хэлбэр хэмээн тодорхойлдог ч, Монголын нийгэмд шийдвэрлэвэл зохих маш олон асуудал байгаа нь тэдгээрийг шийдвэрлэх улс төрийн байр суурь, үзэл баримтлалын альтернатив хувилбаруудыг улс төрийн намуудаас ард түмэн хүсэж байна. Гэвч өөрсдийгөө прагматик хэмээн зарлах улс төрийн намуудын үзэл баримтлалгүйжсэн тэр орон зайг эзэлсэн сонирхлын зөрчилтэй “захиргааны эдийн засгийн”<sup>13</sup> сонирхлын бүлгүүд болон хувирсан бүтцийг ард түмэн улс төрийн нам хэмээн хүлээн зөвшөөрөхөд хэцүү. Улс төрийн нам бол хүн төрөлхтөний соёл иргэншил, улс төрийн харилцааны хөгжлийн том ололт, амжилт төдийгүй хүмүүсийн оюун санааны альтернатив чиг хандлагын илэрхийлэл юм. Монголын улс төрийн намуудын төлөвшил, тэдгээрийн нөлөөгөөр улс төржсөн төрийн алба оршин буй өнөөгийн нөхцлийг тодруулахын тулд улс төрийн намын хөгжлийн талаар товч авч үзэх нь зүйтэй болов уу.

“Улс төрийн намууд үүсэн бүрэлдэх үйл явц нь улс төрийн бодит байдлын өөрчлөлтөөр нөхцөлдсөн улс төрийн тодорхой нөхцөл байдлын хүрээн дэх олон түмний улс төрийн идэвхтэй үйл ажиллагааны дотоод түлхэцүүд (хэрэгцээ, сонирхол, үзэл үнэлэмж)-ээс үүдэлтэй бүхэл бүтэн цогц үзэгдэл мөн.”<sup>14</sup> (Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын систем. 2000.) “М.Вебер намын улиран хувьсах түүхийг тодруулж, гурван үе шатыг дамжин бий болсон гэж үзжээ. Тухайлбал, язгууртны дугуйлан, улс төрийн клубууд болон олон түмний нам гэсэн гурван үе шатыг Их Британий либераль (виги), консерватив (тори) намууд туулж өнгөрүүлсэн түүхтэй... М.Веберийн үзсэнээр олон түмний улс төрийн үйл явц нь олон түмний улс төрийн эрх ашгийг хамгаалсан шинэ мэргэжилтэнүүдийг хэрэглэснээр олон түмний нам бий болсон аж.” (Ц.Ганболд. Улс төрийн шинжлэх ухаан. 2001.) Велдинманн улс төрийн нам бол засгийн газар, институцийг легитимжүүлдэг чухал байгууллага юм гэж тодорхойлсон байна. М.Дюверьеж улс төрийн намуудыг бүтэц, зохион байгуулалтаар нь боловсон хүчний ба олон түмний нам гэж үндсэнд нь ангилж үзжээ. Гэвч М.Я.Острогорский, Р.Михельс нараас хойш зуу гаруй, Дювержегээс хойш дөч гаруй жил өнгөрч, сүүлийн үеийн О.Кирчхаймер, Р.Катц, П.Маир, Р.Хамел, К.Лоусон, А.Пабьянко, К.Жанда зэрэг олон судлаачид орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийг дөрвөн үндсэн үе шатыг дамжсан гэдэгт санал нэгдэж байна. Улс төрийн нам нь аж үйлдвэржилтын үеэс анхлан

<sup>13</sup> А.Надбоёе. Захиргааны зах зээл. [www.openforum.mn](http://www.openforum.mn)

<sup>14</sup> А.Агеев-Удагуй. Иргэдийн бэл дэвдэй гай, гайуу нэндэй. ОА., 2000. ӨНӨ дөгөөд оуаёуа.

нийгэмд эзлэх байр суурь, угсаа гаралгүй ч хөрөнгө мөнгө, баялагийг эзэмшсэн үйлдвэрийн эздийн эрх ашгийг хамгаалах дугуйлан хэлбэрээр үүсэж, консерватив ба либераль чиг баримжаатай элитийн буюу боловсон хүчний намыг дээрээсээ бий болгожээ. Энэ намын онцлог нь бүртгэгдсэн гишүүдийн тоо харьцангуй цөөн, эсвэл ерөөсөө байдаггүйд оршино. Сонгуульд тухайн намд саналаа өгсөн, материаллаг талаас дэмждэг, зохион байгуулсан хурал цуглаанд оролцдог хүмүүсийг гишүүнд тооцдог. Ийм намууд сонгуулийн үеэр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, бусад цагт байгаа байхгүй нь мэдэгдэхгүй шахуу харьцангуй тайван байдаг. Боловсон хүчний намын анхан шатны байгууллага намын дотооддоо ихээхэн чөлөөтэй байж, намын гишүүд нь намын байгууллагаасаа хамааралтайгаа тэр бүр мэддэггүй. Боловсон хүчний нам бол сонгуульд бэлтгэх эсвэл сонгогдсон төлөөлөгчидтэйгээ холбоо харилцаагаа хадгалах зорилго бүхий “нотаблей”-чүүдийн (notable – язгууртан буюу нэр хүндтэй хүмүүсийн) нэгдэл юм. М.Дюверьеже нотаблейн зарим шинжүүдийг илрүүлжээ. 1. Эдгээр хүмүүс нь өөрсдийн нэр, алдар хүндийн тусламжтайгаар тухайн намаас нэр дэвшигчдийн нэр хүндийг өсгөхөд тусалдаг; 2. Нотаблейчүүд бол сонгуулийн компани ажиллагааны ухаалаг зохион байгуулагчид байдаг; 3. Энэ нам нь нийтийг хамарсан өргөн гишүүнчлэлгүй, голдуу сонгуулийн өмнө үйл ажиллагаа нь эрс идэвхждэг; Намд гишүүн элсүүлэх албан ёсны механизм байхгүй. Удирдлагыг нотаблей хэрэгжүүлж, түүний гарт өргөн хэмжээний эрх мэдэл төвлөрдөг онцлогтой. Үүгээрээ сонгодог олигархи бүрддэг хэмээн шүүмжлэгддэг. Гэвч нам дахь элитийн циркуляци нь ҮЭ, олон нийтийн хөдөлгөөний удирдагчидтай холбоо тогтоож, тэдний удирдлагыг намын удирдлагадаа татан оролцуулах замаар явагддаг. Эдгээр намуудын үйл ажиллагаа нь нийгмийн дунд давхрагын эрх ашгийг хамгаалахад илүүтэй чиглэгддэг. Ийм намуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга хэлбэр нь намын санхүүжилтын зардлыг бага төвшинд барьж байх боломжийг олгодог.

Мөн бүх нийтийн сонголтын эрх чөлөө бий болсонтой зэрэгцэн ажилчны хөдөлгөөн, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны үр дүнд радикаль үзэл баримтлалтай олон түмний социалист болон либераль намууд XIX зуунд доод ангийн тэмцлээр үүссэн ажээ. Олон түмний намуудын үүсэл хөгжил нь аж үйлдвэржилтийн үр дүнд нийгмийн ялгарал хүчтэй болж, тэдгээрийн зөрчил гүнзгийрсэнтэй холбоотой. Олон түмний намын хувьд боловсон хүчний намтай харьцуулахад байдал огт өөр. Эдгээр нам зохион байгуулалтын нарийн бүтэцтэй, олон тооны гишүүд дэмжигчидтэй, тэднийгээ хатуу сахилга бат, ямар нэг үзэл суртлын номлолоор барьж байдаг. Намыг санхүүжүүлэх гол эх үүсвэр нь гишүүдийн татвар юм. М.Дюверьеже Францын социалист намын талаар судалсан үр дүнгээ бичихдээ “уг намд шинэ гишүүн элсүүлнэ гэдэг нь улс төрийн болоод санхүүгийн хэрэгцээний үүднээс намын ашиг сонирхолд нийцдэг”<sup>15</sup> гэжээ. (М.Дюверьеже.1964.) Намын байгууллага, гишүүд хоорондоо ойр дөт холбоотой байхыг эрмэлзэх бөгөөд үзэл суртлын ажилд үлэмж анхаарал тавьдаг. Намын удирдлага төвлөрсөн байдалтай, намыг гол төлөв мэргэжлийн улс төрчид удирддаг. Олон түмний нам өөрийн үйл ажиллагааг сонгуулиар хязгаарлалгүйгээр өдөр тутам үзэл суртал, зохион байгуулалтын ажил хийж байдаг. Ийм намуудын парламент дахь намын бүлгийн үйл ажиллагаа нь намын удирдах төв байгууллагын үйл байдлаас ихээхэн хамаардаг. “Олон түмний намуудын үйл ажиллагаа нь нийгмийн доод давхрага, олонхийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байдаг”<sup>16</sup> (М.Я.Острогорский.1905.) нь тэднийг ихэвчлэн нийгмийн чиг баримжаатай, зүүний радикаль болон төрийн зохицуулалттай неолибераль үзэл баримтлалыг удирдлага болгоход хүргэдэг. Тэд юуны өмнө ажилчин ангийн улс төрийн төлөвшил, нийгэмшилтийг хангаснаар засаглал ба удирдлагыг гартаа авах чадвартай элитийг хүрээлүүлнэ гэж үздэг. Өөрөөр хэлбэл,

<sup>15</sup> Î.Äðàäæà. Îëëäð-àíëëà ãäðëë. ãä Çëðà È.À. 2000. <http://yandex.ru>

<sup>16</sup> Îäðããðíëëë Î.В. Äãíëäàðëý è ãëëäð-àíëëà ãäðëë. Ì., 1997.



гишүүнгүй нам гэдэг бол сурагчгүй багш гэсэн үг гэдэг санж. Р.Михельс олон түмний намуудын бүтэц, зохион байгуулалт нь бюрократ тогтолцоогоор ажилладаг бөгөөд, түүнд зайлшгүй “олигархийн төмөр хууль” үүсгэдгийг 1915 онд “Улс төрийн намууд” бүтээлээрээ нотолсон юм. Боловсон хүчний болон олон түмний намууд нь хоорондоо бүтэц-зохион байгуулалт, санхүүжилтын хувьд ялгаатай төдийгүй, үзэл баримтлалын хувьд ч өөр эх үүсвэртэй байсан ажээ.

Гэвч олон улсын байдал, нийгмийн хөгжил нь намуудын хөгжлийн төвшинг өөрчилж, дээрээс болон доороос үүсэх үзэл санааны урсгалыг нэгтгэх болсоноор эдгээр төрлүүдийн холилдсон хэлбэр болох нийтийг хамарсан сонгодог олон түмний намуудын үүрэг роль, нийгэмд эзлэх байр суурь эрс нэмэгдсэн аж. Учир нь 1929-1933 оны чөлөөт эдийн засгийн хямрал хүртэл аль ч нийгэмд ямар ч нам үзэл суртлын ноёрхлоо бүрэн тогтоож чадаагүй байв. (Оросын 1917 оны хувьсгалын үеэс хойш тоталитаризм тогттол, большевик нам доторхи фракциуд ямар нэг хэлбэрээр үндсэндээ оршин тогтнож байсан) Улс төрийн намууд гучаад оны чөлөөт эдийн засгийн их уналтын үер хямралыг зогсоож, нийгмийг зохицуулах их амлалтуудыг өгөн гарч ирсэнээр төр нийгэмд том байр суурь эзлэх үндэс болсон ажгуу. Ийнхүү олон түмний нам гэдэг олигархи бүлэг төр, нийгмийн бүхий л үйл ажиллагааг хяналтандаа оруулаад зогсохгүй, ард түмний оюун ухааныг өмчлөх болсон ажээ. Тухайн нөхцөлд ардчилсан дэглэмтэй улс орнуудад төрийн зохицуулалт давамгайлсан неолиберализмын урсгал гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, дэлхий дахин цэрэг, улс төрийн эвсэлд хуваагдаж, глобальчлал хязгаарлагдсанаар либерализм, чөлөөт зах зээл оршин тогтнох боломжгүй болсон аж. Велдинманн үзэхдээ олон түмний намд хоёр асуудал байна. Эхнийх нь олон түмний намын илт гажуудал, дараагийнх нь сонгогч олон түмнийг өөрийн бааз суурь болгон, тэдний тогтвортой байдлыг хүчээр барьдаг явдал юм гэжээ. С.Липсет, Роккен нар олон түмний намын тархалтыг зүүнтнээс үндэслэгдсэн олон түмний цуглаан, зохион байгуулалтын эсрэг, ялангуяа жижигхэн байсан либераль ба консерватив намууд улс үндэстнээ дээдэлсэн олон түмний шинэ фронт бүрдүүлэн нөмөрт нь хоргодох болсонтой холбоотой юм гэж үзсэн байдаг. Харин Ж.Сартори олон түмний намын “хөлдүү” систем нь бидний эрч хүчийг үлбэгэр байдлаар хувьсгаж байдаг гол учир шалтгаан нь оршино”<sup>17</sup> гэж тодорхойлжээ. Төрийн, хувийн, олон нийтийн ч бай аливаа байгууллага, институцийн оршин тогтнож, үйл ажиллагаа нь төлөвших үндсэн нөхцөл нь тогтвортой санхүүжилт дээр суурилдаг. Өөрөөр хэлбэл, санхүүжилтын асуудал тогтворгүй бол ямар ч байгууллагын үйл ажиллагаа рациональ институц болж төлөвшиж чадахгүй. Дэлхийн практикт авторитар болон тоталитар дэглэмд ихэнхдээ зөвхөн эрх баригч олон түмний нэг намыг л санхүүжүүлдэг. Олон түмний нам нь ардчиллын нөхцөлд хэзээ ч төлөвшсөн институц болдоггүй бөгөөд төлөвшүүлэе гэвэл авторитар, тоталитари дэглэм тогтоож, төрөөс хүчтэй санхүүжүүлэн дээрээсээ төлөвшинө. Гэхдээ ингэж хугацаагүй эрх баригчдын дэмжлэг, төрийн хүчээр төлөвшсөн нам хэнд үйлчлэх нь ойлгомжтой билээ. Формаль ардчиллын нөхцөлд олон түмний хоёр нам ноёрхох боломж байсан боловч, санхүүжилтын асуудал нь бэрхшээл (авилгал, хээл хахуулийн шудрага бус орчныг бүрдүүлдэг) учруулах болсоноор хүссэн хүсээгүй боловсон хүчний намын цомхон бүтэц зохион байгуулалтад шилжсэн байна.

Дэлхийн хоёрдугаар дайны дараах олон ардчиллууд нь олон түмний намын хэлбэрээс аажимдаа татгалзаж эхэлсэнээр намын хөгжлийн гурав дахь үе шат болох “catch-oll” буюу “өргөн хүрээний” намууд бий болж эхэлжээ. (Ё.Довчин. Харьцуулсан улс төр. 2006.) О.Кирчхаймерийн тодорхойлсон “catch-oll” намууд олон түмний намуудын олонхийн эрх ашгийг баримталсан өргөн хүрээтэй бодлого, элитийн намуудын зардал багатай авсаархан бүтэц зохион байгуулалтыг өөртөө шингээн авч, нийгмийг удирдахыг гол зорилгоо болгосон байна. Ийм “catch-oll” намуудын удирдах зорилго сонгуульд

<sup>17</sup> Èà Ìàèñààðà, Æ Ñàðòòèðè . Ìëèèðè-àñèèà ìàððèè. <http://www.sibupk.nsk.su/New/04/chairs/>

“ялсан нь бүгдийг авна” гэдэг системийг төлөвшүүлсэнээр эрх баригч ба сөрөг намын байр суурийг нийгэмд хүчтэй хөгжүүлсэн. Улс төрийн намуудын сөргөлдөх байр суурь нийгмийн амьдралд сөрөгөөр нөлөөлөх болсоноор ХХ зууны наяд онд барууны орнуудад намгүй нийгмийг мөрөөдөх үзэл дэлгэрч абсентизм үүссэн аж. Гэвч нөгөө талаар нам, парламентын олонх, засгийн газар гурвын нэгдэл засаглал хуваах зарчмийн эсрэг улс төрийн хүчтэй бодлого явуулж, неоконсерватизмын төрийн засаглалыг хязгаарлах засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэх үндэс болсон билээ. Засаглалын шинэчлэл нь ардчиллын давалгааны хүчийг нэмэгдүүлсэнээр плюрализмыг өргөн хүрээнд дэлгэрүүлсэн ажээ. Плюрализмын нөхцөлд нийтийг хамарсан гишүүнчлэл бүхий, улс орны өнцөг булан бүрд “аалзны тор мэт хэрсэн” намын анхан шатны нэгжтэй том бүтцийг санхүүжүүлэх нь боломжгүй бөгөөд ингэх нь олон урьгальч үзлийг хязгаарлах төдийгүй намыг санхүүжүүлэхийн тулд авилгын системийг хөгжүүлэх үндэс болно. Ийнхүү өрнөдийн орнуудад олон түмний намуудын шахагдаж үгүй болоход дараах шалтгаан нөлөөлсөн ажээ. Үүнд:

- Орчин үеийн шинжлэх ухаан, техникийн хөгжил дэвшил, мэдээллийн хүртээмж нь улс төрийн намын бодлого зорилгыг гишүүдээр дамжуулан ухуулах шаардлагагүй болсон. Улс төрийн намуудын удирдлага, лидерүүд телевиз, сонин хэвлэл, хэвлэлийн бага хурал, форум зэрэг олон хэлбэрээр ард түмэнтэй шууд харьцах боломжтой болсон төдийгүй, олон түмэн ч тэдний үзэл баримтлал, бодлого зорилгод анализ хийж сонголт хийх нөхцөл бүрдсэн.

- Ардчилал, плюрализмын нөхцөлд тоталитар, авторитар дэглэм шиг намын олон зуун мянган гишүүдийг “номенклатур” болон “spoils system” шиг урамшуулах механизм байх боломжгүй болсон. Аль нэгэн намын гишүүн гэж нийгэмд давуу эрх эдлэж, намын гишүүнчлэлийг амьдралаа дээшлүүлэх хэрэгсэл болгох нь ардчилал, тэгш эрх, олон ургальч үзлийн зарчимд нийцэхгүй аж.

- Ардчилал плюрализмын онцлог нь хүний оюун ухаан, үзэл бодлыг аль нэгэн нам гишүүнчлэлээр дамжуулан өмчлөх ёсгүйд оршино. Эгэл жирийн хүмүүс аль нэгэн намыг дэмжин улс төржин туйлшрах эрүүл бус сэтгэлгээ плюрализмын альтернатив сонголтууд үйлчилж буй нөхцөлд туйлшрал аажимдаа арилж эхэлсэнээр сонголтод прагматик хандах болсон байна.

- Ардчиллын нөхцөлд улс орныг аалзны тор мэт хэрсэн олон түмний намуудын асар том бүтэц зохион байгуулалт, түүний байнгын ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй болсон.

О.Кирчхаймерийн үзсэнээр дайнаас хойш элитийн болон олон түмний намууд нь төр, иргэний нийгмийн харилцааны шинэ үйл явцыг тусгасны үр дүнд “catch-all”<sup>18</sup> намууд үүссэн ажээ. Хүн амын улс төрийн ялгарал багасч, тэдний ашиг сонирхол дахь намуудын урьдын хамаарал саармагжсан нь нийгмийн хамгааллын бодлого, нийт хүн амын ашиг сонирхлыг мөрийн хөтөлбөртөө тусгахыг намуудаас шаардаж эхэлсэн аж. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжилт нь намын удирдагчдыг тухайлсан бүлгүүдэд бус, харин нийт сонгогчдод нэгэн зэрэг хандах бололцоо олгодог болсон зэргээс уг намын төлөвшил эх үндэстэй байв. “Catch-all” буюу “өргөн хүрээний” намууд нийгмийн нэг бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөх бус, харин үндэсний ашиг сонирхлыг удирдлага болгож, олон тооны идэвхтэй гишүүдээс илүү ТВ-ээр дамжуулан сонгогчидтой холбоо тогтоож байдаг лидерүүд давамгайлах чиг хандлагыг үйл ажиллагаандаа тусгах болсон ажээ.” (Ё.Довчин. Харьцуулсан улс төр. 2006.) Өөрөөр хэлбэл, “Catch-all”<sup>19</sup> намууд нь олон түмний намуудын өргөн хүрээтэй бодлого, элитийн

<sup>18</sup> Roper Steven D. The Romanian Party System and the Catch-All Party Phenomenon.

<http://www.questia.com/library/politics-and-government/political-science/political-parties>

<sup>19</sup> Heather Macivor. Do Canadian Political Parties Form a Cartel /The Model of Political Parties / Canadian Journal of Political Science / No. 2 (Jun., 1998)

намын бүтэц зохион байгуулалтын авсаархан онцлогийг шингээж, нийгмийг удирдах төлөөллийг бүрдүүлэхэд чиглэсэн хэв маяг болон гарч ирсэн байна.

Намын хөгжлийн дөрөв дэх үе шат болох “картель” хэв маягийн намууд нь төрийн зохицуулалттай зах зээлийн хямралаас үүдэн 1970-аад оны эцсээр бий болж эхэлжээ. Ардчилал хөгжсөн улс орнуудад намууд асуудлыг шийдвэрлэх өргөн хүрээтэй улс төрийн бодлогуудыг өөр өөрсдийн үзэл суртлын хүрээнд дэвшүүлэн хоорондоо толхилцон тэмцэлдэх нь нийгэм, төрийн байгууламжуудад сөрөг нөлөөлөл үзүүлэх болсоноор сонгогчдын дургүйцлийг төрүүлэх болсон ажээ. Өрнөдийн орнуудад бий болсон 1960-аад оны үзэл сурталгүй нийгмийн тухай төсөөлөл, “хиппи” хөдөлгөөнүүдийн үр дагавар болон 1970-80-аад оны намуудын эрх баригч, сөрөг хэмээн улайрсан тэмцэлд эгдүүцсэн сонгогчдын дунд абсентизм үүсэх нөхцөл бүрджээ. Энэ нь Америк болон Швейцарь зэрэг орнуудад сонгогчдын 49% нь сонгуульд оролцоноор илэрч байв. Тухайн үед хоёр системийн үзэл суртал, улс төр, эдийн засгийн өрсөлдөөн төгсөөгүй байсан явдал, өрнөдийн орнуудын төр, засгийн зүгээс намуудын үйл ажиллагааг хүчтэй дэмжих шалтгаан болсон аж. Улс төрийн намууд төрийн албан тушаалын төлөө хоорондоо өрсөлдөх нь хэвээр боловч, тэдгээр нь үүнийг зохион байгуулалтын хувьд хамтаараа тэсч үлдэх, хэн хэнийхээ ашиг сонирхлыг өрсөлдөгчидтэйгээ хуваалцах, зарим тохиолдолд бүр уралдаж тэмцэлдэх хязгаарлагдмал тэмүүллийг өрсөлдөхгүй байх позитив тэмүүлээр хэрэг дээрээ солихыг хүлээн зөвшөөрөх замаар намын хөгжлийн шинэ хувилбар үүсэн бий болжээ гэж Р.Катц, П.Майр <sup>20</sup>нар 1995 онд дүгнэсэн байна. Намуудад дургүйцсэн олон түмний дургүйцлийг дан ганц төрийн дэмжлэгээр олж авах нь боломжгүй тул, намууд үзэл суртлын хатуу туйлшралаас зайлсхийж, аль болох бусад намуудтай хамтран ажиллах, зөвшилцөх, бусад нам руугаа нэвтрэх буюу тэдний оновчтой сайн зүйлсийг олж харан өөрсдөдөө тусгах, хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх болов. Нөгөө талаар сонгогчид өөрсдийн сонирхлыг ямар нэгэн хатуу сөрөг хүчинд бус, төрийн шийдвэрт бага боловч тусгаж өгч чадах аядуу намуудад найдлага тавих болсоноор картель намын хэв маяг үүсэх болсон. Энэ нь орчин үеийн намуудыг хоорондоо ялгарал багатай мөрийн хөтөлбөрийн ойролцоо байдлыг бий болгосон төдийгүй, намын удирдагчид гишүүдийн хоорондын харилцаа өөрчлөгдөн, удирдагчид сонгогчидтой шууд холбоо тогтоохыг аль болохоор эрмэлзэж, нам ба нам бусчуудын ялгаа тийм ч чухал биш болж ирсэн аж. 1995 онд Р.Катц, П.Маир нар намын байгууллагын зуучлалгүй улс төрчид, сонгогчдын шууд холбоо, өргөн эвсэл, удирдагч сонгогчдын ойрын зайд үндэслэсэн улс төрчдийн мэргэшсэн бүлгүүдийн дунд төрийн албан тушаалуудыг хуваарилах механизм болсон картель намуудын тухай үндэслэгээг дэвшүүлжээ. Намуудын мөрийн хөтөлбөрийн ойролцоо байдал, төрийн бодлогын хариуцлагыг бүх намууд хуваан үүрэхэд хүргэж, энэ нь нөгөө талаар эрх баригч намын хариуцлагыг тодорхой хэмжээнд нимгэлж өгч байдаг нь картель намуудын онцлог болж байна. Өөрөөр хэлбэл, эрх баригч, сөрөг хүчин гэж зааглах явдалгүй парламентад суудалтай бүх намууд төрийн бодлогын хариуцлагыг үүрэлцэхэд чиглэгдсэн байна. Ийнхүү намуудын хэв маяг, тэдгээрийн өөрчлөлт нь ардчиллын загваруудтай ямар нэг талаар холбогдож байдаг аж. Тухайлбал, элитийн нам нь хязгаарлагдмал ардчиллын хүрээнд үйл ажиллагаагаа сайн явуулж, улс төрийн өргөн биш хүрээний дунд элитийн өрсөлдөөн явагддаг. Олон түмний намууд төлөөллийн ардчилалтай холбоотой бөгөөд засгийн эрхийн төлөө өрсөлдөхийн тулд олон нийтийн сонгуулийн оролцоог чухалчилдаг. Мөн эргээд сонгогчдынхоо өмнө хариуцлага хүлээдэг. Өргөн хүрээний намууд плюраль ардчиллын нөхцлийг хамгийн сайн гэж үзээд үзэл суртал болон төлөөллөөр ялгарахыг саармагжуулдаг. Харин

---

<sup>20</sup> Richard S. Katz and Peter Mair. Changing Models of Organization and Party Democracy: The Emergence of Cartel Party, Party Politics. 1995.

мөрийн хөтөлбөрийн хувьд төдийлөн ялгараад байдаггүй, төрийн зүтгэлтнүүдийн нийгэмлэг маягийн картель намууд зөвшлийн ардчиллыг чухалчилж, нийгмийн гол язгуур үнэт зүйлс дээр санаа нэгдэж, ардчиллын шинжийг улс төрийн дэглэмийн легитим гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, намууд парламентад цөөнх болсон хэдий ч шийдвэрт, ард түмний төлөөллөөрөө дамжуулан сонгогчдын хүсэл эрмэлзлэл, түүнд нийцсэн улс төрийн бодлогын альтернатив хувилбараа их бага боловч тусгахыг хичээж, түүнийхээ хариуцлагыг хамтран хүлээхэд чиглэгдэж байна.

Өнөөдрийн Монголын улс төрийн системд намын хөгжлийн эдгээр үндсэн дөрвөн хэв маяг холилдон оршин тогтнож байгаа ч улс төрийн намуудын төлөвшил бүрдээгүй байгаа нь тэдгээрийн санхүүжилт, бүтэц зохион байгуулалтын асуудалтай илүү холбогдож байна. Улс төрийн намуудын санхүү, тагнуулын ерөнхий газраас ч дутуугүй нууц байна. Улс төрийн намуудын тухай хуульд намын санхүүжилтын асуудлыг хамгийн бүдэг, тодорхойгүй байдлаар тусгасан нь үүний нэг илрэл. Мөн удирдах зөвлөлийн болон сонгуулийн сунгаанд оролцогч гишүүдээс нэхэж буй босгын 20 сая төгрөг зэрэг нь намуудыг улам ёс суртахуунгүй сонирхлын бүлэг болоход нөлөөлөөд зогсохгүй, цаашид хэрэгжүүлэх улс төрийн засаглалын үйл ажиллагааг “булингартуулах” үндэс болж байна. Уг нь хамгийн ил тод, нээлттэй байх газар бол намын санхүүжилт билээ.

Т.Парсонсын тодорхойлсон латентны үүрэг гэдэг нь системийн хэвийн байдлыг хангах буюу системийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг хадгалахад чиглэсэн үйл ажиллагаа юм. Нийгмийн шинэчлэл буюу системийн өөрчлөлт нь тодорхой хэмжээнд өөрийн уламжлал, үнэт зүйлсийг хадгалсаар байдаг бөгөөд энэ шинж чанараараа нийгмийн шинэчлэл болгон адилхан байдаггүй. Тийм ч учраас нийгмийн системийн өөрчлөлт нь уламжлалыг хадгалсан улс төрийн системийг бүрдүүлдэг онцлогтой. Гэвч уламжлалт үнэт зүйлс, түүний зарим хэм хэмжээг өөрчлөх явдал улс төрийн системийн зорилго байдаг. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд улс төрийн систем нь шинэ нөхцлийг бүрдүүлэх, түүнд дасан зохицох шаардлагатай тулгардаг. Улс төрийн систем нь өөрөө энэ шаардлагад тулгуурлахгүйгээр, уламжлалт үнэт зүйл, хэм хэмжээнд тодорхой хэмжээнд тулгуурлах нь шинэ, хуучны зөрчлийг гүнзгийрүүлдэг. Энэ зөрчил нь улс төрийн системийн зорилго, түүний тогтолцоог гажуудуулсанаар нийгмийн хямралыг гүнзгийрүүлдэг байна. Яг ийм тохиолдол, өнөөгийн Монголын нийгэм, улс төрийн байдалд бий болоод байна. Уламжлалт үнэт зүйлс, түүний зарим хэм хэмжээг өөрчлөх явдал улс төрийн системийн өөрчлөлтийн зорилго байдаг бөгөөд энэ зорилгыг хэрэгжүүлсэнээр сая систем тэнцвэрээ олж оршин тогтдог. Өөрөөр хэлбэл, “нийгмийн нийтлэг эрх ашгийн үүднээс зарим “давхарсан” үйл ажиллагааг хязгаарлах нь улс төрийн системийн үүрэг юм.” (С.Базарпүрэв. Улс төрийн системийн онол. 2006.) Нийгмийн системийн өөрчлөлт нь нийгмийн нийтлэг эрх ашигт нийцсэн уламжлалт үнэт зүйлс, хэм хэмжээг хадгалдаг бөгөөд харин системийн шинэтгэлийн зорилгод нийцэхгүй үнэт зүйлс, хэм хэмжээг өөрчлөхийг шаарддаг нь нийгмийн хувьслын хууль юм. Өмнөх системд ноёрхож байсан элементийг өөрчлөх нь улс төрийн системийн гол зорилго бөгөөд түүний гадаад нөхцлийг олон намын системд оруулсанаар дотоод мөн чанарыг өөрчлөх эхлэл тавигдсан. Тэгэхээр энэ зорилгыг хэрэгжүүлэгч улс төрийн системийн зорилго тодорхойгүй, түүний үзэл бодол бүрдээгүй нөхцөлд нийгмийн үнэт зүйлсийн өөрчлөлт радикаль болон прагматик хандлагад тулгуурлах бөгөөд нийгмийн хямрал үргэлжилсээр байх болно. Ийм нөхцөлд элитийн болон плюраль ардчиллын сул тал болох нийгмээс тасарсан хүчирхэг сонирхлын бүлгийн хамгийн том хэлбэр болох хоёр намын ээлжилсэн ардчиллын хэлбэрдэлт бий болдог аж. Хүчирхэг сонирхлын бүлгүүд буюу плюраль ардчиллын туйлширсан хувилбар нь нийгмийн бодит хэрэгцээ шаардлагыг орхигдуулж, тэдний өмнөөс бүлгийн эрх ашгийг хадгалсан зохиомол хэрэгцээг санал болгодог онцлогтой. Үүний мөн чанар нь олонхийн нэрээр ардчилсан маягийн хэлбэрдсэн (формал ардчилал) олигархийн дарангуйлалыг агуулдаг. Үүнийг

зарим судлаачид Америк, Европын ардчилал хөгжсөн орнуудаар жишээ татан эсэргүүцэж болох юм. Гэвч эдгээр орнууд: **Нэгд**, тодорхой хэмжээнд хөгжсөн ардчиллын давуу тал болох хувь хүний авьяас чадвар, потенциалийг түлхүү ашиглах боломжийг алхам бүрдээ нэмэгдүүлсээр байдаг оршдог. **Хоёрт**, аж үйлдвэржилт, техник, технологийн хөгжлийн давуу байдлаа ашиглан гуравдагч ертөнцийг мөлжих замаар өөрийн түр тэнцвэрээ хадгалж байдаг. **Гуравт**, тэдгээр улсуудын нийгэм, улс төр, эдийн засгийн болон социаль салбар дахь тогтвортой байдал нь нийгмийн байнгын хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэх процессыг улс төрийн зорилгод бус, эдийн засгийн дасан зохицох үйл явцад суурьлан, прагматик шийдвэрлэх боломжийг олгодог. **Дөрөвт**, эдгээр нөхцлүүд нь ихэвчлэн консерватив болон либерал байр суурьт тулгуурласнаар нийгмийн хөгжлөө жам ёсны шинжтэй мэт харагдуулдаг.

Улс төрийн системийн тогтолцоонд аль нэгэн элементийн хяналт, хариуцлага суларч давуу эрх эдэлбэл, нийгмийн системийн тэнцвэрийг алдагдуулан тогтолцооны гажуудлыг үүсгэдэг. Энэ гажуудал нь улс төрийн дэд систем төдийгүй нийгмийн бусад дэд системд сөрөг нөлөө үзүүлж, улс төрийн системийн зорилго өөрчлөгдөх буюу гуйвдаг ажээ. Улс төрийн системд тэнцвэргүй буюу давуу боломж эдэлж буй элемент нь өөрийн тэнцвэртэй бус, давуу чанараа хадгалж үлдэхийн тулд, тэр давуу боломжоо ашиглан системийг дайчлах болон өөртөө тохирсон тогтолцоог бий болгохыг хүсдэг. Нийгмийн системийн бүтцийн өөрчлөлт нь улс төрийн системийн зорилго, түүний бүтэц-функциональд өөрчлөлтийг бий болгосон бөгөөд тухайн улс төрийн системд урьд нь хадгалагдаж, гол үүрэг гүйцэтгэн ноёрхож байсан (нэг нам хэмээх ) элемент нь гадна, дотны шинэ нөхцөл байдалд дасан зохицох, өөрийн үнэт зүйлсийг хадгалж үлдэхийн тулд нийгмийн шинэчлэлтийг өөртөө тохируулах зорилгоор түүний мөн чанарыг өөрчилж эхэлсэн юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн системд эзлэх байр суурийн давуу байдлаа энэ элемент хадгалж үлдэхийн тулд нийгмийг дайчлан өөртөө тааламжтай нөхцлийг, дотоод, гадаад орчиндоо бүрдүүлж эхэлсэн ажээ. Учир нь хуучин систем дэх давуу эрх мэдэл, байр суурь бүхий элементүүд, шинэ нөхцөлд байр сууриа хадгалж үлдэхийн тулд “мутац” хэлбэртэйгээр төрхөө хувиргадаг бөгөөд ингэснээр улс төрийн системийн өөрчлөлт саармагжиж, хуучин төрхөө шинэ нөхцөл байдлын багаар халхалдаг. Чухам ийм байдал л өнөөгийн Монголын улс төрийн систем дэх хамгийн гол институцийн нэг болох улс төрийн намд нүүрлээд байна. Нэг намын тогтолцоонд байсан номенклатур механизм нь шинэ нөхцөлд, дүр төрхөө өөрчлөн, мөн чанар нь хэвээрээ үйлчлэх бөгөөд ингэснээр эрх барих нэг ба бусад нам гэсэн тогтолцоог төрийн хэрэгжүүлэх механизмд шингээж, түүнд нийцсэн можаритар сонгуулийн хуулийг баталж өгсөн нь аажимдаа хоёр намын ноёрхол тогтох үндэс болсон ажээ.

1990-ээд оны ардчиллын давалгаанаар Монголд үүссэн олон намууд нь олон түмний намын статусыг баримтлах болсон нь дараах хэдэн шалтгаантай байна. **Нэгд**. 1990 оны ардчиллын үйл явцыг нэг ч цонхны шил хагалалгүй тайван замаар хийсний үр дүнд Монголын нийгэм, түүний улс төрийн системд ноёрхож байсан гол элемент болох нэг намын системийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны уламжлалт арга механизм нь улс төрийн системийн бүтцийн өөрчлөлтөд өртөлгүй хадгалагдаж үлдсэн. Өөрөөр хэлбэл, МАХН Дорнод Европт өрнөж буй улс төрийн үйл явцад дүгнэлт хийн ардчилагчдад буулт хийж өгсөнөөр ардчилсан өөрчлөлт тайван замаар явагдсан. Энэ буулт нь МАХН-ыг олон намын системт ардчилал, плюрализмын үед уламжлалт бүтцээ хадгалж үлдэн улс төрийн зах зээлд давуу байр суурь эзлэх бололцоог олгосон юм. Энэ талаар Р.Михельс “Тэдний буулт бол хуурамч зүйл юм. Тэд өөрийн байр сууриндаа үлдвэл, олон нийтийн хүсэл зорилгыг биелүүлэх нэрээр удахгүй өөрийн эрхэмлэгч үнэт зүйлс, ноёрхол зэргээ буцаан сэргээж эхлэнэ гэдгийг сайтар мэдэж байдаг” гэжээ. (Р.Михельс. “Улс төрийн намууд”.1915.) **Хоёрт**. Олон намын системт шинэ улс төрийн зах зээлд МАХН уламжлалт бүтэц, байр сууриа хадгалж үлдэснээр давуу талыг олсон

тул, шинээр төрсөн сөрөг хүчний шинэ намуудыг уламжлалт намтай өрсөлдөх үүднээс хоорондоо нэгдэж бас нэг том нам үүсгэн түүний бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны арга механизмыг нь хуулбарлахад хүргэв. Олон түмний намын хэлбэр нь авторитор, болон тоталитар дэглэмүүдэд амин чухал хэрэгтэй тогтолцоо юм. Учир нь эрх баригчдын легитимийг дээшлүүлэх болон түүний засаглалыг хадгалахад олон түмнийг хамарсан намын гишүүнчлэл онцгой үүрэгтэй аж. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд намын гишүүдэд “нийгмийн онцгой давуу эрх”-ийг (ажлын сайн байртай байх, карер хөөх боломж олгох, гадаад, дотоодод мэргэжлээ дээшлүүлэн сурч боловсрох, орон байраар хангах гэх мэтээр) олгоход л хангалттай юм. “Хүн мөнгөн шан харамжийн оронд нийгмийн онцгой эрх, нөлөөтэй албан тушаал, сайхан орон сууц, хоол хүнс, аялах жуулчлах юм уу боловсрол олох боломж олоо гэхэд энэ нь хүн шилж сонгох эрх чөлөөгүй болно”<sup>21</sup> хэмээн Ф.Хаек үзсэн байдаг. Гэвч Монголд олон түмний намын хувилбар оршин тогтнож байгаа нь дээр өгүүлсэн намын гишүүдэд “нийгмийн онцгой давуу эрхийг” олж авах боломжоо хадгалсаар байгааг харуулж, намаар дамжуулан эрх мэдэл, албан тушаал олж авч, амьдралаа дээшлүүлэхийг хүсэгчдийн сонирхлын том бүлэг болсныг харуулж байна. Харин ардчиллын зарчим нь ийм нийгмийн тэгш бус байдлыг хүлээн зөвшөөрдөггүй. Ийм учраас ардчилсан улс төрийн системд бүх нийтийг хамарсан гишүүнчлэлтэй нүсэр том, намын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо улам бүр зохимжгүй болсоор байна. Ийнхүү олон түмний намын гишүүнчлэлийн систем нь сонгогчдын намыг дэмжсэн тогтвортой байдлыг хүчээр барьж байхад зориулагдсан тогтолцоо болж хувирсан аж.Тэгвэл өнөөгийн Монгол дахь олон түмний намуудын гишүүнчлэлийн онцлог нь “нийгмийн онцгой давуу эрх”-гүй, зөвхөн “намын батлах” өвөртөлсөн жирийн нэг гишүүн, намд ямарч үүрэг гүйцэтгэхгүй нь ойлгомжтой болж, бодит байдалд жирийн гишүүд намдаа саналаа өгөх нь буурсаар байна. Нам ард түмний тэдэн хувь биднийг байнга дэмждэг гэсэн (намын батлахны тоог ардчиллын үед хоосон тоо гэж ойлгож болох) тоо баримт дурьдан байр сууриа илэрхийлэх нь бодит байдалд улам бүр өөрчлөгдсөөр байна. **Гуравт.** Тухайн үед уламжлалт намын бүтэц зохион байгуулалтаас өөр хувилбарыг хүлээж авах олон түмний соёл бүрдээгүй байсан. МАХН-ын хяналтын үр дүнд, янз бүрийн шатны байгууллагуудын нэг нь ч бие дааж ажиллах боломжгүйгээр харилцан сүлжилдэж асан уламжлалт үнэт зүйлс хүмүүсийн оюун санаанд амь бөхтэй оршиж байгаагийн үндэс нь олон түмний нам хэмээх уламжлалт бүтэц зохион байгуулалт хадгалагдаж байгаатай нэг талаар холбоотой. Гэвч нийгмийн шилжилт, үнэт зүйлсийн өөрчлөлттэй уялдан тэдгээр намуудын үйл ажиллагаа ард түмний дунд улам бүр нэр хүндгүй болж байгаа аж. **Дөрөвд.** Нэг намын ноёрхлын үнэт зүйлс болон ардчилагчдын өөрсдийн нь улс төрийн боловсролтой холбоотой, мөн түүнчлэн тэдний олонхи нь уламжлалт марксизмын сэтгэлгээнээс салаагүй байсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн бололтой. Энэ талаар Д.Ганхуяг “Шинэ төрийг шинэ хүмүүс хүмүүс байгуулах ёстой байсан бөгөөд энэ шинэ хүмүүс нь ЗХУ болон социалист орнуудад боловсрол эзэмшсэн хувьсгалчид болсон юм. Эдгээрийн онцлог шинж нь коммунист ирээдүйд шашинлаг байдлаар гүнзгий итгэсэн, нийгмийн гол дайсан нь хар, шар феодалууд болон хөрөнгөтнүүд гэдэг ангийн тэмцлийн онолыг хэт баримталсан”...”гадаад дэмжлэг тусламжид дулдуйдаж, түүндээ эрдсэн, ЗХУ-ын хийж байгаа бүхнийг дуурайдаг, түүнийг догм байдлаар хэрэгжүүлдэг хүмүүс байлаа”<sup>22</sup> гэжээ.

XX зуунтай хамт ард хоцорсон олон түмний намын бүтэц, зохион байгуулалт нь үйл ажиллагаагаа явуулахад асар их хөрөнгө мөнгө шаарддаг автократ механизм бүхий бюрократ тогтолцоо юм. Ийм тогтолцоотой намуудад дотоод ардчилалын асуудал бүдгэрдэг бөгөөд хэлбэрийн төдий зүйл болон хувирдаг. Ардчилал, плюрализмын нөхцөлд нэг улс оронд нийтийг хамарсан гишүүнчлэл бүхий олон түмний намуудыг

<sup>21</sup> Ô.Õääê. 2006. Áíîë-ëíááíð çàì. Îð- Ì.íéæëë. ÓÁ., õ 78.

<sup>22</sup> Ä.Äáíóóÿ. Íííáíë ìáíðäëëðäð. [www.openforum.mn](http://www.openforum.mn)

санхүүжүүлэх явдал нь том бэрхшээл учруулдаг ажгуу. Жишээ нь “МАХН-д аймаг, нийслэлийн МАХН-ын 22 хороо, тэдгээрийн харьяанд НАШБ-ын 303 хороо, 1582 үүр ажиллаж, эгнээндээ 161.5 мянган гишүүнийг нэгтгэж байна”. (Үнэн сонин 2007 оны тоо баримт) Хоёр дахь улс төрийн том хүчин болох АН тоталитар болон авторитар дэглэмд олигархи бүлэглэлийн эрх баригч байр суурийг хадгалах үзэл суртлын зэвсэг болон ашиглагдаж, ард түмний “тархийг угаан”, нам ард түмний нэгдлийг хангах үүрэгтэй ажилладаг байсан олон түмний намын арга барилыг тэр чигт нь уламжлан авсан аж. Үүний үр дүнд “АН-ын гишүүдийн тоо 150 мянгад хүрсэн” (Өдрийн сонин. 2007.) нь тэднийг МАХН-ын адил улс орны өнцөг булан бүрт НАШБ, нэгжийг ажиллуулахад хүргэсэн аж. Монгол дахь нэг намын системийн үед олон түмний намын нүсэр бюрократ бүтцийг гишүүдийн татвар болон төрөөс санхүүжүүлэн үйл ажиллагааг нь төлөвшүүлж байсан билээ. Гэтэл ардчиллын үед, тэр тусмаа амьжиргааны төвшин доройтсон өнөөгийн нөхцөлд гишүүдээсээ татвар авдаг намыг дэмжиж гишүүнчлэлд нь хамрагдан ач холбогдолгүй “хоосон батлах” өвөрлөх жирийн иргэн олодохгүй, нөгөө талаар 161.5 мянга, эсвэл 150.0 мянган жирийн иргэн намын гишүүнчлэлээр дамжуулан нийгэмд давуу эрх эдлэх нь ардчилал, плюрализмын зарчимд нийцэхгүй нь ойлгомжтой. Ийм нөхцөлд намууд өөрсдийгөө дэмжих улс төржсэн эрүүл бус гишүүнчлэлийг бааз сууриа болгож, ямарч үнээр хамаагүй хадгалж үлдэхийг зорьж байгаа аж. Намууд энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд лидерүүд болон идэвхтэй гишүүддээ намаа санхүүжүүлэх мөнгө олох ил, далд (Ил нь босгын 10.0- 20.0 сая төгрөг ба хандив, далд нь гишүүдээ төрийн албан тушаалд томилуулан, эрх мэдлийг нь урвуулан ашиглах арга) даалгавар өгч, тэдний гавьяа зүтгэлийг харгалзан бялуу хуваах механизмаар ажиллаж байна. Энэхүү санхүүжилтын сөрөг тогтолцоо буюу “болхи” механизм нь улс төрийн засаглалд нийгмийн системийн зорилгыг явцуу ашиг сонирхолд үйлчүүлж, зах зээлийн чөлөөт эдийн засагт төрийг ашигласан бизнесийн монопольд дасан зохицохыг тулган, нийгмийн харилцааны хэм хэмжээ, түүнийг боловсруулах үйл явцыг дээрх хоёр зорилгод нийцүүлсэн лоббид автуулан, нийгмийн оюун санааг (улс төр гэдэг бүхнийг мөнгөөр хэмждэг бохир зүйл, угаасаа ийм байдаг гэсэн ойлголт төрүүлж ) энэ бол жам ёсны хэмээн төөрөгдүүлж, ирээдүйдээ болон намуудад үл итгэх хандлагыг бий болгон, нэг хүний засаглал, намгүй нийгмийг мөрөөдөхөд хүргэж байна. Системийн онолын хандлагаар авч үзвэл энэ нь жам ёсны харилцаа биш. Ийнхүү Монголын улс төрийн системд олон түмний намыг санхүүжүүлэх асуудал нь авилгын систем хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг болж байна.

Сүүлийн арван долоон жилд Монголд бий болсон олон түмний гэх статустай намууд нь, улс төрийн засаглал, төрийн бодлого, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд үүний үр дүнд нийгмийн амьдрал түүний хөгжил дэвшилд эсрэг үр дүн гарсан ажээ. Ардчиллын нөхцөлд олон түмний намын бүтэц, зохион байгуулалт нь улс орны иргэдийг хагалан бутаргаж, хуваагдалд оруулаад зогсохгүй, үндэсний нийтлэг эрх ашиг, эв нэгдлийг сарниулахад тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Учир нь олон түмний нам нь тоталитар болон авторитар дэглэмд нэг үзэл суртал болон эрх баригч бүлгийн ноёрхлыг хадгалахын тулд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулан, ард түмнийг намын оршин тогтнох бааз суурь болгож, ард түмний нэр барин засаглаж ирсэн. Хэн ард түмний нэрийг их хэмжээгээр барьж ярина, тэр хэмжээгээр дарангуйлах бололцоо нэмэгддэг. Өөрөөр хэлбэл, “хамгийн их хүнд сурталтан, хамгийн их хүнд суртал хэмээн ярьдаг”<sup>23</sup> гэдэгтэй ижил ажгуу. Харин ардчилсан улс төрийн системд ард түмний оюун санааг албан ёсны гишүүнчлэлээр өмчлөх нь плюрализмын зарчимд нийцэхгүй төдийгүй, дээрх үр дагаварт хүргэж, олон түмний оюун санааг хэт улс төржүүлэн талцуулсан ажээ. Энэ талцалт нь төр, захиргааны дээд, доод төвшинд хүчтэй нөлөөлөн төрийн алба улс төржсөнөөр шинэчлэлтийн үйл явцыг саармагжуулсан

<sup>23</sup> Ἄλλοδαῶδες. ἱ.ῖοί. Ἀοίῃῃ. /Ἀῖῖῖῖῖῖ ἄῖῖῖ ῖῖ. / ὈἈ., 2001.Ἴῖῖῖ Ὀῖῖῖῖ Ὀῖῖῖ.

байна. Монгол дахь олон түмнийг хамарсан гишүүнчлэл бүхий улс төрийн бүх намууд нь орон нутагт шат, шатны намын байгууллагуудтай нүсэр том бюрократ тогтолцоо бүхий автократ аппарат болсон. Ингэснээр зохион байгуулалтын ажлын зардал эрс нэмэгдэхээс гадна намын удирдлага, жирийн гишүүдийн хоорондох шат дамжлага ихэссэн аж. Р.Михельс “ямарч институцийн хөгжил нь бюрократ буюу шатлан захирах ёсны төлөвшилт, удирдлагын онцгой давхраатай холбоотой байдаг. Цагийн явцад энэ давхраа нь засаглалын эрхийг дангаар барьж, олон түмнээс тасарч, зөвхөн өөрийн байдлыг хадгалан үлдэхэд л анхаарсан олигархи болж хувирдаг”<sup>24</sup> гэжээ. Нөгөө талаар жирийн гишүүд ба удирдагчдын нийгмийн байдал болон орлогын ялгаа нь зайлшгүй олигархийг бий болгодог байна. Олигархиуд нь намын бюрократ дахь шат, шатны санал хүсэлтийг ардчилсан байдлаар ёс мэт хүлээж авдаг ч түүнийг тооцож хэрэгжүүлдэггүй. Энэ нь нэг талаар олигархи удирдагчид болон анхан шатны нэгжийн гишүүдийн мэдлэгийн төвшин харилцан адилгүй байдагтай, нөгөө талаар намын иерархи шатлалт нүсэр бюрократ тогтолцоотой, мөн тэдний нийгмийн социаль ялгаралтай холбоотой ажээ. С.Липсет социаль ялгарлыг бууруулах явдал олигархиас зайлсхийх боломжийг олгоно гэж үзсэн нь ардчилал хөгжсөн орнуудад олон түмний намын бүтэц зохион байгуулалтаас татгалзах үндэслэлүүдийн нэг болсон аж. “Бүтэц, зохион байгуулалтын хувьд олон түмний хэмээх категорит хамаарагдах намын боловсон хүчний чадвар сул байдаг нь улс төрийн үйл явцыг оновчтой шийдвэрлэх чадваргүй парламентийг бүрдүүлэх нэг үндэслэл болдог”<sup>25</sup>. Учир нь орчин үеийн ардчилсан улс орнууд нь парламент дахь улс төрийн намуудын улс төрийн бодлогын зөвшилцөл дээр тулгуурлан төрийн бодлогыг гаргах болсон агаад үүнийг прагматик хандлага гэдэг санж. Институцжээгүй, төлөвшөөгүй нам, мэргэшээгүй улс төрчдөд улс төрийн бодлого гэж бараг байхгүй бөгөөд харин явцуу ашиг сонирхлын хуйвалдаан болон наймаалцахаа зөвшилцөл гэх болсон байна. Олон түмний намын бүтэц зохион байгуулалтын нэг онцлог бол намын гишүүд нь ихэвчлэн хэт улс төржсөн байдаг учраас сөрөг намын оновчтой саналыг хүлээж авах чадвар сул, дэмжсэн нэгийгээ урвагч шарвагчаар нь дууддаг талтай. Олон түмний намын бас нэг дутагдал бол лидерүүдээ даган туйлшрах үзэгдэл болон лидерүүдийн байр сууриас хамаарч намын улс төрийн бодлого тогтворгүй байдаг явдал юм. Ийм намын гишүүдийн олонх нь улс төрийн боловсрол, мэдлэг сул байдаг тул, хэн нэгэн лидерийг тахин шүтэх хэлбэрээр дагах явдал түгээмэл байдаг. Учир нь олон түмний намуудын лидерүүд мэргэшсэн улс төрчид болдог. Өөрөөр хэлбэл, мэргэшсэн гэдэг нь тухайн ажлыг хийж, цалин авч, тэр хэрээрээ дадлагажин туршлагажиж буй хүнийг хэлдэг. Харин өөр ажил хийж буй эмч, багш, инжинер намын харьяалал бүхий хэн ч байсан тэдний олонх нь үндсэндээ улс төрийн хувьд сонирхогчид эсвэл хавсрагчид. Гэхдээ хэн нэгэн хувь хүний онцлог, улс төрийн сонирхлын давуу тал, мэргэших чадварыг үгүйсгэж болохгүй нь мэдээж. Гэвч улс төрд гарч ирэх магадлал нь лидер дагасан сонирхогчидод илүү үйлчилдэг. Шүтэн бишрэгч сонирхогчидоор хүрээлүүлсэн лидерийн цээж томордог. Энэ нь намыг дотор нь лидерүүдийн хэд хэдэн бүлэглэлд хуваадаг бөгөөд эдгээр бүлэглэлүүдийн тэмцэл хатуу ширүүн явагддаг бөгөөд тэд ялахын тулд “чөтгөртэй” ч хуйвалдахад бэлэн байдаг аж. Өөрөөр хэлбэл, улс төрийн асуудалд мэргэшээгүй, тодорхой үзэл сурталд баттай суурьлагдаагүй хүмүүсийн нэгдэл сул байдаг. Тийм ч учраас тэдгээр сонирхогчид лидер сольж, хүчний давуу тал руу эргэхэд бэлэн байдаг онцлогтой. Нөгөө талаар олон түмний намын гол онцлог болох лидерийн үзэл баримтлал буюу хувь хүний эрх мэдэлд хүрэх тоглолт улс төрийн засаглалд онцгой нөлөө үзүүлдэг. Гэтэл орчин үеийн эрх зүйт төрийн зарчим нь институцсэн улс төрийн бодлого, түүний системтэй хандлагыг нэхдэг. Улс төрийн

<sup>24</sup> Michels R. 1968. The Bureaucratic Tendency of Political Parties. / Reader in Bureaucracy/ NY., Coller. Macmillan Limited

<sup>25</sup> А.Аюүиүр. А.Иаоүеё. Е.Нодн. Д.Ааёуою. Оабуооёёнаг оёё д°д. Ид- .Аиа-ёи.ОА., 2005. ИОЁН-ёеи оүаёёё.



намууд институужиж чадаагүй нөхцөлд явцуу ашиг сонирхлын нэгдэл давамгайлах хандлага илрэх бөгөөд энэ нь тогтвортой итгэл үнэмшилд тулгуурласан нэгдэл болж чадахгүйгээс гадна, нам доторх хагарал, бутрал, дотоод тэмцлийг идэвхжүүлдэг. Энэ байдал нь улс төрийн бодлого, түүний зорилго, зорилтыг нь тогтвортой бус байдалд оруулж, хууль бус лобби нэмэгдэх төдийгүй, нийгмийн зүгээс ирэх шаардлагуудад рационал бус амлалтууд өгч, зөвхөн засаглалыг олж авч явцуу сонирхолыг давамгайлуулах болон хадгалахад чиглэгддэг байна. Ийм ямар ч үзэл баримтлал, бодлого зорилгогүй ойрын бодлоор сэтгэж, гал унтраах үүрэг гүйцэтгэгч намууд үүнийгээ байх ёстой прагматик хандлага хэмээн зөвтгөдөг.

Ардчилал хөгжсөн орнууд бүтэц зохион байгуулалтын хувьд боловсон хүчний намын хувилбарыг сонгох болсон үндсэн шалтгаан дараах хандлагатай холбоотой ажээ. **Нэгд**, Мэргэшсэн улс төрчид, элитүүдийн хооронд мэдлэгийн төвшний ялгарал бага байх учраас хэн нэгнийг дагаж туйлширдаггүй, аливаа асуудалд хариуцлагатай, мэдлэгтэй, шүүмжлэлтэй хандах боломж бүрддэг. **Хоёрт**, Тэдний нийгмийн социаль ялгарал бага байдаг учраас, гишүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил, нийгэмд эзлэх байр суурийн ялгарал бага байдаг нь аливаа асуудалд тэгш эрхтэй оролцох боломжийг илүү бүрдүүлдэг. **Гуравт**, намын бюрократ төвлөрөл бага байдаг нь дотоод ардчиллын нөхцлийг илүүтэй хангадаг зэрэг нь олигархиас сэргийлэх бүтэц зохион байгуулалтын дотоод үндэс юм. **Дөрөвт**, Үйл ажиллагааны хувьд нийтийг хамарсан том бүтэцгүй тул, ажлын ачаалал буурч, эрч хүчээ нийгмийн мэдрэмжид чиглүүлэн бодлого тодорхойлон дэвшүүлэхэд илүү институциональ ханддаг. **Тавд**, Намын санхүүжилт, түүнд зарцуулах төсөв хөрөнгийн бэрхшээл буурдаг.

Орчин үеийн зарим ардчилсан орнууд болон Монголын улс төрийн намуудад дараах үзэгдэл ажиглагдаж байна. Үүнд: **Нэгдүгээрт**, судлаачдын үзэж байгаагаар “орчин үед намуудын ихэнх нь үзэл суртлаа тууштай хамгаалахаас илүүтэйгээр прагматик хандлагатай байхыг эрмэлздэг болсон”<sup>26</sup> байна. Энэ нь аливаа нам өөрийнхөө цэвэр үзэл сурталтай зууралдаж сонгогчдын эгдүүцлийг хүргэж, ялагдал хүлээснээс, сонгуульд ялахыг урьдал болгодог рациональ бодлого прагматик хандлагыг бодитойгоор оршин тогтноход хүргэдэг аж. Энэ нь улс төр, эдийн засгийн хувьд тогтвортой нийгэмд байж болох үзэгдэл юм. Учир нь нийгэм тогтвортой хөгжиж буй үед улс төрийн үзэл суртлын хэрэгцээ шаардлага бага байдагтай холбоотой. Харин системд бүтцийн өөрчлөлт хийн шилжиж буй болон хямралтай улс орнуудад энэ нь тохиромжгүй бөгөөд тэнд улс төрийн үзэл бодол бүхий рационал удирдлага зайлшгүй хэрэгтэй. Прагматик гэдэг нэр томъёо туйлын зорилго болох аваас засгийн эрхийг авахад болгоомжгүй ашигласны үр дагавар болох ямар ч алсын хараагүй, бодлого, зорилгогүй үйл ажиллагаа явуулахад хүрдэг. Үүнийг энгийн жишээн дээр буулган авч үзвэл нэгэн байгууллагын дарга дөрвөн удаа солигдсон тохиолдолтой адил юм. Тодруулбал, нэгэн ...р цэргийн ангийн захирагч дунджаар 1.5-2 жилийн хугацаатайгаар дөрвөн удаа солигдсоноор тус ангийн харьяаны нэгэн газар түрүүчийн захирагчдын бариулсан объектыг буулган нурааж, өөр, өөр объект ( халуун усны газар, сахилгын шорон, биеийн тамирын талбай, тохиролцооны дэлгүүр гэх мэт) бариулж байсан бөгөөд энэ нь мэдээж нилээд их хэмжээний хөрөнгийг үргүй зарцуулсан нь байгууллагын хувьд төлөвлөсөн тодорхой бодлого, үзэл баримтлалгүйг харуулсан жишээ юм. Иймэрхүү прагматик шинжтэй бодлого нь тодорхой нэг үзэл баримтлалтай системтэй улс төрийн бодлогыг төлөвшүүлэхгүй байх үндэслэл болж, нам нь зөвхөн тухайн лидерийн үзэл бодол, түүний имиж, нэр хүндэд тулгуурласан, тогтворгүй шинж чанарыг агуулдаг. Энэ нь олон түмний хэмээх ангилалд хамаарах намуудад лидерүүддээ тулгуурласан, тэднийг дагаж туйлширсанаас тодорхой үзэл баримтлалаа алдаж, олон түмний үзэл бодлын итгэл үнэмшилд тулгуурласан шинж чанараа гээхэд хүргэдэг. Үүний үр дүнд намууд үзэл

<sup>26</sup> Ìàððàéí Ñëàíí. Ìʹ ðýíà.ÓÁ., 2005. õ 194.

баримтлалын зөрчилт шинж чанарыг дотооддоо агуулсанаар, үзэл бодол, итгэл үнэмшилд тулгуурласан намын шинж чанараа алддаг. Ингэснээр янз бүрийн ашиг сонирхлын үндсэн дээр нэгдсэн түр зуурын шинж чанартай бүлгүүд, тэдгээрийг дэмжсэн тойрон хүрээлэгчдийн буюу өөрөөр хэлбэл улс, үндэсний эрх ашиг, үзэл суртал, итгэл үнэмшилд тулгуурлаагүй, зөвхөн бүлгийн лидертээ үнэнч, эсвэл түүнийг аялдан дагалдагч, тэндээс ашиг хонжоо (рационал сонголт) олохыг хүсэгч хувь хүн бүхий неопатримон, улс төр, бизнес, төрийн албан хаагчдын гурвалжин сүлжээ бүхий неокорпоратив бүлэглэлүүдийн, ард түмний нэр барьсан нэгдэл болж хувирна.

**Хоёрдугаарт**, Монгол дахь аливаа улс төрийн намууд төрийн алба хашдаг өөрийн гишүүдийн тоог өсгөх хандлагатай болсон байна. Энэ нь намуудын эрх баригч болон хамгийн том хүчтэй сөрөг хүчин байх, байнгын монополь эрхийн төлөөх тэмцлийн үр дүн юм. Улс төрийн зах зээлд монополь байдлаа хадгалахын тулд өрсөлдөгч гол хоёр нам төрийн аппаратад гишүүнчлэлээ хадгалах болон нэмэгдүүлэхэд илүүтэй анхаарах болсон нь улс төржсөн төрийн албыг дэмжиж, төрийн чадвар болон автономийг сулруулах нэг үндэс болж байна. Энэ нь нийгэмд хуваагдмал эрүүл бус уур амьсгал бий болгож, тэднийг эс дагагчдад (эрүүл сэтгэгчид болон эргэлзэн тээнэгэлзэгчид, мөн ихэнх нь үл ойлгогчид буюу, хэвөгчид)- ыг татах улс төрийн бодлого төрийн бодлогын залгамж чанарыг эвдэж байна. Нөгөө талаар неоинституционализмын хандлагад институтжсэн зохион байгуулалтын тогтолцоо субъектив хүчин зүйлүүдийн нөлөөлөлд өртөн, оновчгүй байх явдал түгээмэл байдгийг шүүмжилдэг. Гэхдээ албан ёсны бүх зохион байгуулалт рациональ төлөвлөгөөг бүрдүүлэхийг зорьдог бөгөөд түүний олон улсын болон дотоодын амьдралыг зохион байгуулах оролдлого нь мэдлэг мэргэшил, техник технологийн нөөцөд тулгуурлан, зохион байгуулалтын механизмын төгс хэлбэрийг бүрдүүлэхэд оршдог. Хэдийгээр тийм ч, салангид болон бүхэл буюу нэгдмэл нам, эвсэл, иргэний нийгмийн системүүд эсэргүүцлийг сөрж, бүгд хоорондоо харилцан хамтран ажиллаж, өөрсдийн тусгай асуудал, зорилго болон зохион байгуулалтын хэв загвар, байгаль орчны дарамт ба бүх нийтийн оролцоо зэргийг харгалзах ёстой байдаг нь прагматик хандлага юм. Үр дүн нь нийгмийн бүтэц зохион байгуулалтыг тохиромжтой байлгах явдал мөн. Үүний ач холбогдол нэмэгдсээр байгаа асуудал болох хүрээлэн буй орчин, нийгмийн эдийн засаг, соёл, социаль бүтцийн зохион байгуулалтыг бүрдүүлэх болон улс төрийн амьдралыг хянах зорилгоор нээлттэй байлгахад чиглэгддэг. Ардчилсан засаглалын гол асуудал нэг нь улс төрийн үйл явц дахь засаглалыг хэрэгжүүлэгч бюрократ байгууллагыг судлах, түүний зохистой байдлыг тогтооход улс төрийн шинжлэх ухааны оролцоог шаардаж эхэлсэн явдал юм. Тиймээс үүнийг хэрэгжүүлэгч захиргааны бюрократ механизмыг оновчтой ажиллуулахын тулд, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд, тэдгээрийг гадна, дотноос нь хянах, төр засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудын олон механизм байж болох ч, төрийн аппаратуудыг намын харьяаллаас цэвэрлэхгүйгээр төрийн чадвар, автономичанарыг хангах нь боломжгүй юм. Эдгээр чанар хангагдаагүй нөхцөлд төрийн аппарат субъектив хүчин зүйлсийн нөлөөлөлд өртөх төдийгүй, чадавхи сул байх учраас рационал байж чадахгүй. Өөрөөр хэлбэл, субъектив хүчин зүйлсийн нөлөөлөл нь мэдлэг мэргэшил, техник технологийн нөөцөд тулгуурласан зохион байгуулалтын рационал механизмыг бүрдүүлж чадах үндэсгүй болгодог.

**Гуравдугаарт**, орчин үеийн улс төрийн намууд нь олон түмний гэхээсээ илүү үзэл суртал, үнэт зүйлст тулгуурласан улс төрийн бодлого, өргөн хүрээтэй мөрийн хөтөлбөртэй, чадварлаг цомхон, боловсон хүчний буюу мэргэшсэн намын тогтолцоонд шилжих хандлага нэмэгдэж байна. Нөгөө талаар орчин үеийн нийгэм намуудын үзэл суртлын зөвшилцлийг дэмжих хандлага түгээмэлтэй холбоотой. Төрийн албыг намын харьяаллаас салгаж, төрийн албаны төвийг сахих зарчмыг хэрэгжүүлж буй орнуудад олон түмний намын бүтэц зохион байгуулалт нийгмийн зүй зохисоор аажимдаа

шахагдан үгүй болсон аж. (Недерланд, Герман, Франц гэх мэт) Өөрөөр хэлбэл, ямар нэгэн ашиг хонжоо, нийгэмд эзлэх байр суурийн давуу талгүй бол жирийн хүмүүс намын гишүүн байх нь ямар ч ач холбогдолгүй болсноор иргэд улс төржихөө больсон аж. Харин ардчиллын нөхцөлд нам төлөвшинө гэдэг нь тодорхой үзэл санаанд тулгуурласан, дотоод ардчилал бүхий нээлттэй, системчлэгдсэн рационал бодлогын дагуу нийгэмд тулгамдсан аливаа асуудлуудын шийдлийг олох, альтернатив хувилбарыг боловсруулагч мэргэшлийн институц бүрдүүлэх явдал юм. Үүний тулд нийгмийн мэдрэмжтэй байх нь улс төрийн намын гол шинж бөгөөд хувь хүн, хэсэг бүлэг, олонхийн сонирхолын ялгарлыг сонгон нэгтгэж тодорхой үзэл суртлын үүднээс шийдвэрлэх улс төрийн бодлого боловсруулдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам нь нийгмийн хөгжлийн альтернатив хувилбарыг илэрхийлэгч оюуны төв бөгөөд олонхийн сонирхолын тусгал болж, энэ сонирхолыг харгалзсан улс төрийн бодлого боловсруулж, дэмжлэг хүлээдэг институц юм. Энэ сонирхол дэмжигдвэл нийгмийг удирдах эрхийг олж авдаг олон түмний үзэл бодлын альтернатив хувилбарын нэг. Ийм учраас улс төрийн нам нь мэргэшсэн улс төрчид элитүүдээс бүрдэх явдал өрнөдөд уламжлагджээ. Энд мэргэшлийн гэдэг үгийг ойлгоход мэргэшсэн эмч, багш нарт эрүүл мэнд болон хүүхдийнхээ боловсролыг даатгахтай адилтгаж болно. Гэтэл улс төрийн үйл явцад нийгмийн амьдралыг өөр мэргэшилтэй хавсрагчидад даатгах нь дэндүү хариуцлагагүй үйл явц юм. Эндээс гарсан алдаатай бодлого олон сая хүний амьдрал хувь заяаг өөрчилж байгаа билээ.

Түүхэн хуудсыг эргэн сөхөж үзвэл, ардчилсан улс орнуудад улс төрийн нам, хүчин үүсэн бүрэлдэх нь жам ёсоор болж байв. XIX зууны үед ардчилсан улс орнуудад ард олон сонгуулийн эрхтэй болсноор намууд нь сонгуульд ялах гол хөдөлгүүр болж хувирсан. “Сонгууль явагддаггүй байсан цаг үед намуудын хэрэг байсангүй. Шууд томилогдох, эсвэл өв залгамжлан төрийн алба хаших нөхцөлд улс төрийн байгууллага байгуулах шаардлагагүй байж. Харин өөрийг нь дэмжигчдийн тойрон хүрээллийг бэхжүүлэн түүнд тулгуурлах нь ашигтай байв. Харин жирийн иргэд намуудыг нийгэмд хагарал, бутрал үүсгэгч хэмээн тэдэнд үл итгэх нь бий. Үнэн хэрэгтээ, намууд түүхэндээ нийгэм доторх хуваагдмал байдлаас улбаалж үүссэн аж. Санаа нийлсэн хүмүүс улс төрийн зорилгоо харилцан тохиролцож, түүнийгээ хангахын тулд улс төрийн байгууллагад эвлэлдэн нэгддэг байна. Ийнхүү улс төрийн намууд ардчилсан үйл явцын шууд үргэлжлэл болж байдаг”<sup>27</sup> аж. Нөгөө талаар улс төрч гэдгийг түмний төлөө амь биеэ нэгэн үзүүрт сэтгэлээр зориулагчдыг хэлдэг. Харин өөрийнхөө ашиг сонирхлын төлөө тэмцэгчдийг бизнесмен гэдэг. Түүхийн явцад хэн байх нь хамаагүй, өөрөөр хэлбэл, нийгэмд болохгүй байгаа зүйлийг өөрчлөхийг хүсэгчдийг улс төрч хэмээн нэрлэж байв. Тэд зөвхөн оновчтой шийдвэр гаргахад л төрийн мэргэшсэн машин рацианаль биелүүлнэ. Гэвч орчин үеийн нийгмийн хөгжил, хөдөлмөрийн хуваарийн нарийсалт нь нийгмийн тулгамдсан асуудлыг хэн нэгэн “бүдүүн баргаар” шийдвэрлэх боломжгүй болгож байна. Иймээс мэргэшсэн улс төрч, улс төрийн бодлогын мэргэшсэн институц буюу намууд, тэдгээрийн альтернатив хувилбар шаардлагатай болж байна. Шинжлэх ухаанд нийгэм дээр туршилт хийдэггүй гэж үздэг. Гэвч бодит амьдралд олон түмний намууд сонирхогчид болон хавсрагчдад нийгмийн амьдралыг шийдвэрлэх эрхийг олгож, туршсаар байна. Тэд үүнийгээ алдаж онох эрхтэй гэж зөвтгөх ёс суртахууны үндэс байж болохгүй. Энэ туршилтуудын үр дүнд нийгмийн гишүүд ядуурал, гэмт хэрэг, авлига, өвчин зовлон зэрэг олон хүндрэлийг туулж, ганц олдох амь, амьдралаа алдсаар байна.

<sup>27</sup> Ì.Ñëáíí. Ìʻᠢ ᠳᠦᠶ᠋ᠠ. ᠓ 195

Ном зүй

- Альмонд Г. Пауэлл Ж. Стром К. Дальтон Р. Харьцуулсан улс төр. УБ., 2005. Орч Ё.Довчин. МУИС-ийн хэвлэл.
- Ашфорд Н. 2007. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. Адмон ХХК.
- Вебер М. 2000. Улс төр бол мэргэшил мөн, Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. Орч Ү.Нямдорж. УБ.,
- Бастиа Ф. 2007. Хууль, Шудрага нийгэм байгуулах сонгодог хөтөлбөр. УБ., Орч Н.Баярбаатар. Адмон ХХК.
- Базарпүрэв С. 2006. Улс төрийн системийн онол. УБ., ЭКИМТО ХХК.
- Болд-Эрдэнэ Д. 2000. Монголын улс төрийн нам, намын систем. УБ., ФСХ төслөөр хэвлэв.
- Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа. 2005. Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн түүний хувь заяа, УБ., ШУА Түүхийн хүрээлэн.
- Гүндсамбуу Х. Номенклатурчид. /Бодрол бясалгал/ сэтгүүл. 1992., д 8.
- Даль Р. Ардчиллын тухай. /Ардчилал гэдэгт бид юу ойлговол зохилтой вэ./ УБ., Орч Д.Ганхуяг, Ч.Энхбат. Адмон ХХК.
- Дюверже.М. 2007. Улс төрийн байгууламж Үндсэн хуулийн эрх зүй. УБ., ННФ, Монсудар ХГ.
- Довчин Ё. Харьцуулсан улс төр. УБ., 2006, Битпресс ХХК.
- Дюверже.М. 2007. Улс төрийн байгууламж Үндсэн хуулийн эрх зүй. УБ., ННФ, Монсудар ХГ.
- Сланн М. 2005. Улс төрийн удиртгал. Хүйтэн дайны дараах эрин үеийн засгийн газрууд ба үндэстнүүд. УБ., Орч Ё.Довчин. МУИС, МННХ.
- Сьюзан Роуз-Аккерман. 2007. Авлига, төр хоёр. УБ., NERKO publishing.
- Фукуяама Ф. 2005, Төрийг бэхжүүлэх нь. XXI зууны засаглал ба дэлхийн шинэ дэг журам.УБ., Монсудар хэвлэлийн газар.
- Вебер М. Избранные произведения. М., 1990.
- Восленский М. Н. Номенклатура. М., 1990.
- Дюверже М. Политические партии. М.,1994.
- Жилас М. Шинэ анги. /Коммунист системд хийсэн анализ. Лицо тоталитаризма. М., 1992.
- Инглхард Р. Постмодерн: меняющиеся ценности и изменяющиеся общества. Полис, 1997. <sup>1</sup> 4.
- Острогорский М.Я. Демократия и политические партии. М., 1997.
- Перегудов С., Семенов И. Лоббизм в политической системе России // Мировая экономика и международные отношения. 1996 <sup>19</sup>, х.30.
- Dahl R.A. 1989. Democracy and Its Critics. New Haven.
- Easton. D.A. 1967. Systems Analysis of Political Life. Second Edition. New York.,
- Lipset S.M. 1959. Some Social Requisites of Democracy: Economic Development and Political Legitimacy. — American Political Science Review, vol. 53, № 1.
- Michels R. The Bureaucratic Tendency of Political Parties. / Reader in Bureaucracy/ NY.,1968. Collier.Macmillan Limited
- Merton R 1968. Social theory and Social structure. New York: Free Press.
- Neumann F. 1968. Total Bureaucratization and the Powerless Individual. / Reader in Bureaucracy/ NY.,Collier.Macmillan Limited
- Heather Macivor. Do Canadian Political Parties Form a Cartel /The Model of Political Parties / Canadian Journal of Political Science / No. 2 (Jun., 1998)
- Parsons T. 1967. Sociological theory and modern society . NY., Free Press,
- Richard S. Katz and Peter Mair. Changing Models of Organization and Party Democracy: The Emergence of Cartel Party, Party Politics. 1995.
- М.Дюверже. Политические партии. пер Зимина Л.А. 2000. <http://yandex.ru>
- Ла Паломбара, Ж Сартори . Политические партии. <http://www.sibupk.nsk.su/New/04/chairs/>
- Roper Steven D. The Romanian Party System and the Catch-All Party Phenomenon. <http://www.questia.com/library/politics-and-government/political-science/political-parties>